МАНАЙ СОНИНЫ I УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,125.672... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.01.10. Мягмар. №005 (4619) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




ЦАГ ҮЕ

Б.ЭНХБАЯР: ХОРИХ ЯЛААС АЛЬ БОЛОХ ТҮДГЭЛЗСЭН

IV нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙГ УЛААН ГЭРЛЭЭР БАТЛАХЫН УЧИР...

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Иргэдийн ухамсрыг дээшлүүл...

Б.СУМЪЯА

"Дэлхийн хамгийн их утаатай хот"-ыг шалгаруулан шагнал өгдөг бол Улаанбаатарт тэр шагналыг олгочих юмсан гэх утга агуулга бүхий мэдээ Японы нэгэн сайтад гарсан байсан санагдана. Доог тохуу юм шиг атлаа, үнэн хэрэгтээ манай хотын агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрсэн нь дэлхийн чихэнд хүрсэн гэдгийн баталгаа нь энэ байлаа. Гэхдээ ганц энэ жил гэнэт л нийслэл утаанд автчихсан юм биш. Сүүлийн хэдэн жилийн турш "Азийн цагаан дагина" гэгдэж явсан Улаанбаатар хот "Утаанбаатар" хэмээн цоллуулж, үе үеийн төр засаг утааны эсрэг тэмцсэн ч, төдийлөн үр дүнгээ өгч чадаагүй юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# ТӨР ТҮШИЛЦЭГЧДИЙН НАСНЫ БОСГЫГ НЭМЬЕ




Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын их хурлын сонгуульд 25, Ерөнхийлөгчийн сонгуульд 45 нас хүрсэн хүн өрсөлдөх эрхтэй. Хуулийнхаа дагуу шүү дээ. Тиймээс 25 нас хүрсэн л бол УИХ-ын сонгуульд өрсөлдөж, бүр гишүүн болох боломж байгаа, хүн бүрт. Ерөнхийлөгчийн сонгууль бол арай өөр зарчимтай. Парламентад суудалтай намаас нэр дэвших боломжтой, тэгээд 45 нас хүрсэн байх ёстой гэх зэргээр шалгуур нь үл ялиг өндөр. Гэвч парламентын засаглалтай болж, сонгууль явуулж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл хугацаанд болсон үйл явцаас харахад насны босго хэт намдаад байна уу даа гэлтэй. Монголчууд бид эрт дээр үеэс "Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас" хэмээн сургаж ирсэн ард түмэн.

Үргэлжлэл нь III нүүрт




ДЭЛХИЙ

## БРАЗИЛД 100 гаруй ялтан амь үрэгдлээ

Б.ДАВААХҮҮ

Бразилын Амазонас мужийн Мануас хотын шоронгийн ялтнууд эмх замбараагүй байдал үүсгэсний улмаас долоо хоногийн дотор 100 гаруй хүн амь үрэгдсэн харамсалтай хэрэг гарчээ. Хамгийн сүүлд гэхэд өнгөрөгч ням гарагт тус шоронд дахин үймээн дэгдэж, дөрвөн ялтан нас барсан байна. Ингэснээр нэг долоо хоногт зөвхөн тус шоронд нас барсан ялтнуудын тоо 100-г давлаа. Мануас хотын шорон нь ихдээ 592 хүмүүжигч хүлээн авах хүчин чадалтай аж. Гэтэл саяхныг хүртэл хэт ачаалал авч 1224 хоригдол хүмүүжиж байсны улмаас ялтнууд хоорондоо муудалцан зодолдож, нэг нэгийнхээ толгойг таслах, зүрхийг гаргах гэхмэтчилэн хүний санаанд оромгүй харгис хэрцгий авир гаргаж, ердөө хэдхэн хоногийн дотор л зуугаар тоологдох хүн амьсгал хураагаад байна. Энэ шоронгийн үйл ажиллагааг хувийн компани эрхлэн явуулдаг бөгөөд шоронд хэчнээн хоригдол хүмүүжиж байгаагаас хамаарч улсаас дэмжлэг авдаг аж. Гэвч улсаас мөнгө авахын тулд хэт их ачаалал авсны улмаас энэ мэт аймшигт аллагын хэрэг гарч буйг эх сурвалжууд онцолж байгаа юм. Түүнчлэн, өнгөрөгч долдугаар сард Бразилын хоёр томоохон хар тамхины бүлэглэл болох "PCC", "Улаан цэргүүд" бүлэглэлүүдийн хооронд байгуулсан гал зогсоох хэлэлцээр нуран унасан байдаг. Түүнээс хойш шоронгуудад эмх замбараагүй байдал үүсч, хоригдлууд нэг нэгийнхээ амийг бүрэлгэх хэрэг гаарчээ. Амазонас мужийн эрх бүхий албан тушаалтны хэлснээр хамгийн сүүлд дөрвөн хоригдол амиа алдсан байна.

Үргэлжлэл нь VI нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Данийн иргэн Централ цамхагт тэсрэх бөмбөг тавьсан уу

"Централ цамхагийн 13 дугаар давхарт бөмбөг тавьсан" гэх мэдээлэл өчигдөр 17:00 цагийн орчимд цацагдаж эхэллээ. Албан бус эх сурвалжийн мэдээлж буйгаар Централ цамхагт ажиллаж байсан хүмүүс болон тэнд байсан хүмүүсийг тусгай, онцгойгийнхон яаралтай гарахыг шаардаж, аваарын шатаар гадагш гаргасан гэнэ. Тиймээс Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэн Ё.Лхагвасүрэнгээс энэ талаар тодруулахад "Улаанбаатар хотын төв Централ таурын зургадугаар давхарт "Бөмбөг дэлбэлнэ" гэж сүрдүүлсэн хэрэг өнөөдөр /өчигдөр/ гарлаа. Сүрдүүлсэн иргэнийг саатуулж, Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн албан хаагчид хэргийн газарт тэсэрч, дэлбэрэх бодис байгаа эсэхийг илрүүлэхээр шуурхай ажиллаж байна" хэмээсэн юм.

Дээрх этгээд Централ таурын зургадугаар давхарт байрлах Канад улсын Элчин сайдын яамны байранд тус улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдтай уулзахаар 16:00 цагийн орчимд очсон боловч Эчин сайдын яамны зүгээс тухайн иргэнд уулзуулах боломжгүй гэсэн хариу өгснөөр ийнхүү сүрдүүлсэн аж.

Энэ үед Централ таурын хамгаалалтын албаныхан цагдаагийн байгууллагад хандаж, дуудлага өгсөн байна. Дуудлагын дагуу Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн албан хаагчид газар дээр нь ирж, ажилласан нь энэ ажээ.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТЕХНОЛОГИ ТӨСЛИЙН ЗУУХААР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ

Н.БАТЗАЯА

Улаанбаатар хотын агаарын бохирдол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тогтоосон аюултай хэмжээнээс аль хэдийнэ дөрөв дахин ихэссэн хэмээх аймшигтай тоо баримт сүүлийн үед чих дэлсэх болсон. ДЭМБ-аас агаар дахь хорт бодисын хэмжээний дээд хязгаарыг 501 хэмээн заасан байдаг. Гэтэл нийслэлийн зарим дүүрэг, хороодод энэ тоо дөрөв дахин ихсэж 3000 хол давж байгаа юм. Гэхдээ энэ аймшигтай тоо гэв гэнэт гараад ирсэн гэвэл өрөөсгөл. Хэдэн жилийн өмнөөс тодорхой арга хэмжээ авахгүй бол Улаанбаатар хотын агаарын бохирдол маш аюултай хэмжээнд хүрэх талаар холбогдох албаныхан сануулсан хэдий ч дорвитой арга хэмжээ авахгүй байсаар эдүгээтэй золгосон. Эдүгээтэй гэдэг нь агаарын бохирдлын маш аюултай нөхцөлтэй гэсэн үг. Энгийнээр хэлэхэд нийслэлийн иргэд гадаа удаан хугацаагаар байх боломжгүй болжээ. Ялангуяа, гэр хороолол, Дэнжийн мянга, Баянхошуу гэх зэрэг газарт таван минутаас дээш зогсоход л хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд агаарын бохирдол үүссэн байна.

Үргэлжлэл нь VII нүүрт



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2494.00 | 2505.00 | ФУНТ | 3010.00 | 3111.00 |
| ЕВРО | 2598.00 | 2666.00 | РУБЛЬ | 40.20 | 43.70 |
| ИЕН | 21.10 | 21.45 | ЮАНЬ | 360.00 | 365.40 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2493.00 | 2505.00 | ФУНТ | 3025.00 | 3115.00 |
| ЕВРО | 2597.00 | 2676.00 | РУБЛЬ | 40.54 | 44.78 |
| ИЕН | 21.03 | 21.67 | ЮАНЬ | 361.00 | 366.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ХААЛТТАЙ ХУРАЛДААНААС

## Хөгжлийн банкны шалгалтын материалыг нууцын зэрэглэлээс гаргав



Ж.ОТГОН

УИХ дахь МАН-ын бүлгийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар бүлгийн дарга Д.Хаянхярваа, УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, Б.Жавхлан нар мэдээлэл хийлээ. Бүлгийн хурлын үеэр УИХ-ын гишүүн Ж.Энхбаяраар ахлуулсан ажлын хэсэг Хөгжлийн банкинд хийсэн шалгалтын дүнг танилцуулсан байна. Мөн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийн танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт хийсэн байна. Үүний дараа Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн төслийн танилцуулгыг УИХ-ын гишүүн Ц.Цогзолмаа танилцуулжээ.

Бүлгийн дарга Д.Хаянхярваа хэлэхдээ "Хөгжлийн банктай холбоотой асуудлыг хэн нэгэн хүн рүү хандаж эзэн биегүй ярихгүй. Болсон юмыг болоогүй мэт, болоогүй зүйлийг болсон мэт яриад явaад байдаг. Өнөөдрөөс эхлээд ийм зүйлд цэг тавина. Яагаад гэвэл Хөгжлийн банкны шалгалтын материалыг нууцын зэрэглэлээс гаргасан. Гэхдээ бүх зээлдэгч нарын мэдээллийг нийтэд цацахгүй. Хамгийн анхаарал татсан асуудлыг дэлгэнэ. Ардчилсан намын бүлгийн дарга С.Эрдэнэ "Хөгжлийн банк 580 сая ам.долларын бонд босгосон. Тэр хөрөнгөөр хүний хөгжлийн 21 мянган төгрөг олгоход зарцуулаад дууссан" гэж хэлсэн. Тухайн үед би Сангийн сайд байсан. Хөгжлийн банкны босгосон 580 сая ам.доллараас нэг цент ч зарцуулалгүй эд нарт хүлээлгэж өгсөн. Хамгийн эхний гүйлгээ нь наймдугаар сарын 27-нд эхэлсэн байдаг. Цаашид эзэн биегүй ярихгүй гэдэг шийдэлд хүрсэн" гэлээ.

Харин Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслийг судлах ажлын хэсэг байгуулахаар болсон байна. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн төслийг Засгийн газар өргөн барьсан. Мөн эмэгтэй гишүүд Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн төслийг өргөн барьсан. Иймд нэгтгээд хэлэлцэх нь зүйтэй гэж шийджээ. Ийнхүү МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа бүлгийн хурлаар хэлэлцсэн асуудлаар мэдээлэл өгсөн юм.

## Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 94 заалтыг өөрчилж байна



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ дахь АН-ын бүлгийн ээлжит хурал өчигдөр боллоо. Хурлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, Л.Болд, Ажлын албаны дарга Д.Золжаргал нар бүлгийн гишүүдэд мэдээлэл өглөө. Бүлгийн хурлаар уг асуудлыг хэлэлцээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн талаар УИХ-д суудалгүй улс төрийн намуудын төлөөллийг хамруулж, энэ долоо хоногт багтаан хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Мөн хурлаар Хөгжлийн банкны үйл ажиллагаанд шалгалт хийсэн ажлын хэсгээс мэдээлэл сонсох байсан ч Ажлын хэсгийн ахлагч Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр ирээгүй учир уг асуудлыг дахин хойшлуулжээ. УИХ дахь Ардчилсан намын бүлэг Хөгжлийн банкны үйл ажиллагаанд шалгалт хийсэн ажлын хэсгээс мэдээлэл авахаар хоёр дахь удаагаа зарласан ч ийнхүү ажлын хэсгийн гишүүд болох Сангийн яам, Монголбанкны төлөөлөл ажлын хэсгийн ахлагчгүйгээр тус ажлын хэсгийг болон Хөгжлийн банкийг бүрэн төлөөлж чадахгүй гэлээ. Иймд УИХ дахь Ардчилсан намын бүлгээс Хөгжлийн банкны үйл ажиллагаанд шалгалт хийсэн комиссоос мэдээлэл хийх шаардлагыг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэхээр болсон аж. Энэ талаар УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж хэлэхдээ "Хөгжлийн банкны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүгнэлтийг өнгөрсөн долоо хоногт сонсох ёстой байсан. Гэвч ажлын хэсэг болон Хөгжлийн банкийг төлөөлөх чадамжтай албан тушаалтан хүрэлцэн ирээгүй. Өнөөдөр ч мөн адил чадамжтай төлөөлөл ирсэнгүй. Тиймээс Хөгжлийн банкны шалгалтын дүнг МАН-ынхан хоёр удаагийн сонгуулиар улс төрийн зорилготой ашигласан гэдэг нь харагдлаа. Ялангуяа Хөгжлийн банкийг мэргэжлийн байгууллагаар шалгуулсан бол өнөөдөр ийм нөхцөл байдал үүсэхгүй байсан гэж манай бүлэг үзсэн. Иймд дараагийн долоо хоногийн даваа гарагт дахин мэдээлэл хийх шаардлагыг Ерөнхий сайдад хүргүүлнэ. Сонгуулийн тухай хуулийг салгаж Ерөнхийлөгчийн сонгуульд зориулан боловсруулж байгаа нь цаанаа учир шалтгаантай. Өөрөөр хэлбэл МАН-ынхан өөртөө ашигтайгаар Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг найруулж байж мэдэх юм. Энэ хуулийн төсөлд заасан УИХ-д суудалтай нам гэдгийг тайлбарлах оролдлого нь Үндсэн хуулийн цэцэд очих маргаан дагуулж байна. Тиймээс УИХ-д суудалтай, суудалгүй намуудын төлөөллийг оролцуулж энэ долоо хоногт багтаан хэлэлцүүлэг зохион байгуулна" гэлээ. Харин Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн ямар заалтыг эсэргүүцэж байгаа талаараа "Уг хуулинд техникийн чанартай өөрчлөлтүүдийг хийж байгаа гэж хууль санаачлагчид тайлбарласан. Бодит зөрчилтэй заалтыг өөрчилнө гэж байсан. Гэтэл өмнөх хуулиас 94 заалтыг өөрчилж байна. 100 орчим зарчмын зөрүүтэй саналыг оруулсан. УИХ дээр нэлээн том ажлын хэсэг гараад өнгөрсөн бямба гарагт анхны хуралдаанаа хийсэн. Өнөөдөр хоёр дахь хуралдаанаа хийнэ. Энэ хурал дээр бид байр, суурьа илэрхийлнэ. Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль эрх ашгийн зөрчилгүй байх ёстой юм. Гэтэл өнөөдөр энэ хуулийг өргөн барьж байгаа хүмүүс болон хэлэлцэж байгаа байнгын хороо, УИХ-ын удирдлагууд бүгд эрх ашгийн зөрчилтэй байгаа. Энэ хүмүүсээс "Та нар Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихгүй болоод эрх ашгийн зөрчилгүй ийм том хууль гаргах гээд байна уу" гэж асуухад хэн ч тодорхой хариулт өгөөгүй. Үнээс үзвэл тэр хүмүүс Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэсэн үг. Тэгэхээр тодорхой хүмүүс өөрсдийнхөө сонгуульд зориулсан хууль боловсруулах гэж байна. УИХ-д суудалтай намуудын талаар одоогийн хүчин төгөлдөр хуулийн дагуу цоо шинэ тогтолцоог оруулж ирсэн. Өмнө нь пропорционалиар санал хураах байсан. Одоогийн шинэ хуулиар бүх гишүүдийг ард иргэдээс шууд сонгож байгаа. УИХ-д суудалтай нам гэдэг Үндсэн хуулийн тайлбарыг шинэ хуулийн хүчин төгөлдөр хуулинд байхгүй болсон. Өнөөдөр энэ хуулинд дахин өмнөх хуулинд мөрдөж байсан УИХ-д суудалтай нам гэдэг бол тухайн нам эвслээс нэр дэвшиж сонгогдсон УИХ-ын гишүүн бүхний нам, эвсэл гээд Үндсэн хуулиндаа тайлбар хийсэн заалт орчихоод байна. Үүнийг аль нэг нам хууль, санаачлагч гишүүн бус Үндсэн хуулийн цэцээс маргаан үүсэн нөхцөлд шийдэх ёстой" гэсэн юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭЛЭЛ

## Н.Учрал хүүхдийн эмнэлэгт дулаан хөнжил бэлэглэлээ



УИХ-ын гишүүн Н.Учрал өчигдөр Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн эмнэлэгт ажиллаж хувиасаа дулаан хөнжил болон үлээдэг халуун хөшгийг бэлэглэлээ. Тус дүүрэг нь нийт 115 мянган хүүхэдтэй юм. Харин хүүхдийн эмнэлэг нь 165 хэвтэн эмчлүүлэх ортой. Сүүлийн үед ханиад томууний дэгдэлт ихэсч, нөхцөл байдал хүндэрснээс үүдэн нэмэлтээр 50 ортой нэг тасгийг нээн ажиллуулсан байна. Яг өнөөдрийн байдлаар ачаалал ихтэйгээр буюу 245 хүүхдэд үйлчилж байгаа аж. Тус эмнэлгийн ерөнхий эмч н.Галсанцэдэн энэ ачаалалтай үед анхаарал хандуулж, туслаж, дэмжиж байгаа УИХ-ын гишүүн Н.Учралд талархсанаа илэрхийлээ. УИХ-ын гишүүн Н.Учралын хувьд парламентад сонгогдсоноосоо хойш уг эмнэлэгт гурав дахь удаагаа ажиллаж байгаа юм байна. Тодруулбал, өнгөрсөн намар хэт халалтын үеэр тус эмнэлгийн эм хадгалалтын хөргүүрийн систем нь эвдэрсэн байхад шийдвэрлэж өгчээ. Мөн ханиад томууны дэгдэлт эхлэх үеэр очиж эмнэлгийн нөхцөл байдалтай танилцаж хүчилтөрөгчийн аппарат бэлэглэжээ. Тиймээс ч УИХ-ын гишүүн Н.Учралын хувьд утаа ихтэй хүнд үед сонгогдсон тойргийнхоо хүүхдийн эмнэлэгт эм тариа болон хүчилтөрөгчийн аппарат зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр туслахыг Улаанбаатараас сонгогдсон бусад гишүүддээ уриалж байгаа юм. Харин ирэх жилээс утааг багасгах асуудлаар шинжлэх ухаанч ажлыг хамтдаа эхлүүлэх хэрэгтэйг онцоллоо.

ШАР МЭДЭЭ

## М.ЭНХБОЛД

## Японд "десант буулгах" уу



УИХ-ын дарга М.Энхболд тэргүүтэй төлөөлөгчдийн гадаадын улс орнуудад хийх айлчлал үргэлжилж, мэдээ мэдээлэл нь ч цаг алдалгүй цахим ертөнцөд нийтлэгдсээр байгаа.

Хамгийн сүүлд л гэхэд Япон улсад айлчлах талаархи асуудал хөндөгдөж эхлээд буй. Тодруулбал, УИХ-ын даргыг Элчин сайд М.Такаока ирэх сард Японд айлчлахыг урьсан юм. Тэгвэл ирэх сард УИХ-ын даргыг хэн хэн дагалдаж явах нь олны сонирхлыг татаж эхлэв.М.Энхболд дарга аль ч улсад айлчилсан алзахааргүй олуулаа явдаг. Хэвлэлийн албаных нь мэдээлэлд дурьдсанаар, түүнийг УИХ, Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Эрчим хүчний сайд П.Ганхүү, УИХ-ын гишүүн Н.Энхболд, Ж.Бат-Эрдэнэ, Г.Мөнхцэцэг, Б.Наранхүү, О.Содбилэг, Г.Тэмүүлэн нарын 10 гаруй хүн дагалдан явдаг нь бараг хэнд ч ойлгомжтой болсон юм. Тэгвэл Японд айлчлах мэдээлэл гарсны дараа сошиал ертөнцийнхөн "М.Энхболд дарга Японд десант буулгах нь дээ" хэмээн жиг жуг хийлцэж эхэлсэн гэнэ шүү.

## Нийслэлийн АН иргэдийн хурлаа хуралдуулахыг шаардлаа

Нийслэлийн АН нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Сандуйд шаардлага хүргүүлжээ. Шаардлагад "НИТХ дахь АН-ын бүлгээс санаачлан 2016 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдөр "Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах" сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан. Бид Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2017 оны төсөвт агаарын бохирдлыг бууруулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гурван тэрбум 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг яаралтай ирүүлэх, олон нийтэд мэдээлэх талаар НЗД-ын орлогч, Нийслэлийн харьяа агентлагт албан бичиг хүргүүлсэн боловч хариу өгөөгүй байгаа. Тиймээс төсвийн мөнгө хэзээ, хаана ямар зориулалтаар зарцуулагдах нь тодорхойгүй, хотын удирдлагууд агаарын бохирдлын асуудалд ач холбогдол өгөхгүй байгаагийн тод жишээ юм. НИТХ дахь АН-ын бүлгээс энэхүү асуудалд нухацтай хандаж үүсэн гарч буй нөхцөл байдалд тохирсон шийдэл олох, гамшигт нөхцөл байдлыг даван гарах оновчтой шийдвэрийг цаг алдалгүй НИТХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэх шаардлагатай гэж бид үзэж байна. Иймд "Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний тухай, "Нийслэлийн эрүүл мэндийн салбарын нөхцөл байдлыг сайжруулах" асуудлаар НИТХ-ын ээлжит бус чуулганыг нэн яаралтай зарлан хуралдуулахыг НИТХ дахь Ардчилсан намын бүлэг шаардаж байна. Шаардлагыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд НИТХ-ын дарга, НЗД болон холбогдох албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох асуудлыг тавина гэдгээ үүгээр мэдэгдье" гэжээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

## Иргэдийн ухамсрыг дээшлүүл...

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Хэчнээн ч тэрбум төгрөгийг нүдэнд үзэгдэж, гарт баригдах үр дүнгүй зарлагадав. Тэгвэл “Мэргэжлийн” гэх Засгийн газраас утааны эсрэг бодит арга хэмжээ авах үүднээс гэр хорооллын цахилгааны хэрэглээний шөнийн тарифыг тэглэх шийдвэр гаргаж, энэ сарын 1-ний өдрөөс эхлэн биелүүлэхээр болсон. Ингэснээр гэр хорооллын 146 мянган өрх 21:00-06:00 цаг хүртэл бүх л шөнийн турш үнэгүй цахилгаан ашиглах боломжтой болсон юм. Гэхдээ 146 мянган өрхийн 110 гаруй мянга нь хоёр тарифт тоолууртай. Тиймээс үлдсэн 36 мянган өрх хоёр тарифт тоолуурыг худалдан авч байж, цахилгааны хөнгөлөлт эдлэх боломжтой болж байгаа. Эл шийдвэр гарсны дараа буюу хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсний дараа манай сонин “Speak out” буландаа иргэдийн байр суурийг сонирхсон юм. Ингэхэд, уулзсан гэр хорооллын иргэд бүгд л цахилгааны үнэ хямдрах нь ашгүй гэцгээж байв. Харин нүүрс түлэхээ больж, цахилгаан халаагуур хэрэглэх бодол байна уу гэх асуултад “Боломж гарвал авна даа” хэмээн хариулж байлаа. Нэг талаар, Засгийн газраас нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нүүрсний хэрэглээг аль болох багасгаж, айл өрхийг цахилгаан халаагуур хэрэглэх боломж нөхцлөөр хангах үүднээс дээрх шийдвэрийг гаргасан. Гэтэл нөгөө талдаа, сарын цахилгааны төлбөр нь 20 мянгаас дээш гардаг гэр хорооллын айл өрх хэдэн төгрөг хэмнэгдэх нь хэмээн сэтгэж суух. Гэр хорооллын 146 мянган өрхийн дотор янз бүрийн л амьдралтай хүмүүс бий. Нүүрснээс татгалзаж, цахилгаан халаагуур худалдан авч хэрэглэх санхүүгийн боломжтой нэгэн байхад, нүүрсээ ч худалдан авч дийлэхгүй яваа гундуухан нэгэн ч бий байх. Гэхдээ эх орныхоо хөгжил цэцэглэлт, ирээдүй хойчийнхоо эрүүл мэндийг бодоод амьдралынхаа буруу дадалд эргэлт хийвэл ямар вэ. Өнөөгийн нөхцөл байдалд тохирсон элдэв төрлийн цахилгаан бага зарцуулдаг, дулаанаа хадгалдаг, шалнаас халдаг гэх мэтчилэн халаалтын төхөөрөмжүүдийг монгол инженерүүд ур ухаанаа гарган бүтээж, боломжийн үнээр худалдаж буй жишээ маш олон байна. Хамгийн гол нь тэд мэдээллээ хүмүүст хүргэж чаддаггүйд л учир байгаа юм. Төр засгаас шөнийн цахилгааных нь тарифыг тэглэчихээд байхад “Тогны мөнгө багасах нь” гээд суугаа нөхдүүдэд эрүүл мэнд, эдийн засгийн үр ашгийг нь сайтар ойлгуулж, мэдээллээ сайтар түгээх хэрэгтэй байна. Ер нь ч тэгээд эх орноо байг гэхэд ирээдүй болсон үр хүүхдүүдээ эцэг эхчүүд нь бодоод бас хайрлаад энэ зэргийн ухаан гаргачихад яагаад болохгүй гэж. Өнөөдрийн өөхнөөс маргаашийн уушги гэх үг байдаг даа. Өмнө нь төр засгаас хямд үнээр иргэдэд төслийн зуух нийлүүлж байсан удаатай. Утааг л багасгах гэж. Гэтэл ихэнх айлууд нь зуухаа хэдэн бор төгрөгний төлөө зарчихсан байх жишээтэй. Нийслэлийн өнгө төрхөд иргэн бүрийн оролцоо чухал. Одоо үнэгүй юм хүлээгээд суух хөг өнгөрсөн. Хүн бүр л оролцож, хичээж байж, бидний эх орон хөгжиж цэцэглэх учиртай.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

# ТӨР ТҮШИЛЦЭГЧДИЙН НАСНЫ БОСГЫГ НЭМЬЕ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ чинь эхлээд хувь хүн бол, амьдрал үз, босго, дараа нь улс орныхоо төлөө зүтгэ гэж байгаа хэрэг биз дээ, ерөнхийд нь ойлговол. Харин өнөө цагт бол их, дээд сургууль төсгөөд, дипломтай болчихвол, тэгээд жаахан мөнгөтэй, орлого сайтай бол улс төр рүү ор гэсэн үг хэмээн ойлгодог болчихоод байна. Тиймдээ ч дөнгөж 30 шүргэж яваа, жаахан татаастай, сонгуульд өрсөлдөхөд гарах зардлыг гаргачих боломжтой болсон залуучууд УИХ-ын гишүүн болохоор зүтгээд байна. Яг үнэндээ тэд биеэ, гэрээ засахын ухааныг мэдээгүй, ойлгоогүй л яваа шүү дээ. Тийм байж улс засалцах гэж хөөрцөглөөд л. Улс засалцах ч гэж дээ, төрд гарахаар баяждаг балай жишиг тогтчихсон болохоор тийшээ зүтгээд байхгүй юу. Тийм болохоор УИХ-ын болоод Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүмүүсийн насны босгыг нэммээр байна. УИХ-ын сонгуульд гэхэд 35 нас хүрсэн хүн өрсөлддөг байя. Харин Ерөнхийлөгчийн сонгуульд 55 нас хүрсэн хүмүүсийг өрсөлдүүлье. Насны босгыг 10 жилээр нэмнэ гэсэн үг. Тэгж байж өөрийгөө олчихсон, үзэл бодол нь төлөвшсөн, амьдралд хөл тавьчихсан хүмүүс төрд гарна шүү дээ. Дунджаар 45-60 насны хүмүүс гишүүн болж, төрд ажиллах нөхцөл бүрдэнэ гэж ойлгож болно. Одоо бол 40-55 насныхан голдуу УИХ-ын гишүүнээр ажиллаж байгаа. Цаашлаад 60 гарсан, 70 шахсан цөөн хэдэн гишүүн бий. Мөн 30-40 настай гишүүд цөөн хэд байна. Гэтэл 40 хүрээгүй, эсвэл дөнгөж 40 насны босго давж байгаа залуучууд тийм сүрхий ажиллаж байгаа бил үү. УИХ-ын хамгийн залуу Д.Гантулга гээд нэг нөхөр байна. Одоо л дөнгөж 30 нас хүрч байгаа юм гэнэ билээ. УИХ-ын чуулган, байнгын хорооны хурандаа суудаг ч юм уу, үгүй ч юм уу. Хамгийн олон удаа хоцорсон, чуулган, хурал тасалсан гишүүдийг манлайлж яваа юм гэсэн. УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж нэг хэсэг хурал даргалахдаа түүнийг л жишээ татаж ярьсан. Өглөө ч орноосоо босож чадахгүй л нэг бацаан гай нь таараад гишүүн болчихоод, улс орны ажлаас хойш нь чирээд л явж байна. За тэгээд, 40 хүрээгүй, эсвэл дөнгөж гарч яваа гишүүдийн хийж байгаа ажил, хэлж байгаа үгийг анзаараад нэг үзээрэй. Зүгээр л нэг гал халуун хүсэл, зоригоос цаашлахгүй. Үсчсэн шинжтэй л байгаа шүү дээ. Ядаж байхад сүүлийн үед баян, эрх мэдэлтэй хүмүүсийн хүүхдүүд шууд автоматаар улс төрд орж ирдэг болчихсон. Гэр хорооллын гудамжаар алхаж ч үзээгүй. Гал яаж түлдэг талаар ч ойлголтгүй шахам нөхдүүд ард түмэн гэж худлаа яриад л саарал ордонд сууж байна. Ийм байхад яаж улс орон өөдөлж, дэвжиж, иргэдийн зовлон нимгэрч, жаргах вэ дээ. Дээрээс нь өндөр албан тушаалд очихоороо залуучууд улсын ажил хийхээсээ илүүтэй хоцорсон, тасалсанаараа хошуучилж, элдэв хүүхэнтэй нэр холбогдож, эд хөрөнгө хураахын “дон тусаж” л байна. Өөр юу гийгүүлсэн юм, юугаар ч гийгүүлээгүй. Тэгвэл 50 гарсан, биеэ, гэрээ засчихсан, авах идэхийн хүсэл нь арай багасчихсан, улс орноо гэсэн сэтгэл нь арай илүү дэвэрчихсэн хүн гишүүн болбол арай өөр дөө. Ядаж л шөнөжин шоудаад, маргааш нь шартаад хэвтээд байхгүй л байх. Тэгэхээр Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг ч ялгаагүй өөрчилж, насны босгыг нэмье. Эд улс орны төлөө зүтгэж, оюун ухаанаа уралдуулж явах ёстой 50 гаруй насны хүмүүс Ерөнхийлөгч болоод л улс төрийн замналаа өндөрлөх болчихоод байна. П.Очирбат гуайгаас эхэлье л дээ. Ерөнхийлөгчийн албанаас буугаад л улстөрчийн замнал нь өндөрлөсөн гэхэд болно. Гэтэл нас нь яагаач үгүй байдаг. Ингээд л Үндсэн хуулийн цэц рүү явсан. Ямар Ерөнхийлөгч байсан хүн дахиад гишүүн болоод яваад байлтай биш гэж бодоо байлгүй. Мөн хажуугаар нь хувийн компанид зөвлөх энэ тэр хийгээд байсан санагдана. Ерөнхийлөгч байсан хүн тэгж зөвлөх хийх ёстой ч юм уу, бүү мэд. Н.Багабанди гэдэг хүн бас л ид ажиллах насандаа л Ерөнхийлөгчийн албанаас буусан. Дараа нь мөн зөвлөх хийж нэг хэсэг явсан байх. Сүүлдээ “Титэм үг” нэртэй нэвтрүүлэг хийж, ном хүртэл гаргасан. Хүмүүст мартагдахгүйн тулд хийж байсан ажил юм уу даа, янз нь. Гэтэл тэр хүн төрд ажиллаад, УИХ-ын гишүүн байсан бол бацаануудаас арай дээр шүү дээ. Н.Энхбаяр гэдэг хүн ч Ерөнхийлөгчийн албанаас буух үедээ 50 гаруйхан настай байсан. Улс орондоо ид ажиллаж байх ёстой цаг. Гэтэл улстөрчийн замнал нь дуусчих гээд байдаг.

Ингээд л МАН-ын ад үзсэн “Х” үсгэн дээр тоглолт хийж, шинэ нам байгуулж, бөөн юм болгоо биз дээ. Тэгээд одоо дахиад Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх боломжийг хайгаад, бужигнуулж л байна. Яаж ид насан дээрээ зүгээр л улс төрөөс холдоод, ном бичээд, орчуулга хийгээд суугаад байх вэ дээ. Одоогийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн бүрэн эрх энэ жил дуусна. Гэтэл тэрбээр 55 нас хүрээгүй байна. Бас л төрд олон жил ажилласан, туршлагатай, чадвартай хүний улс төрийн замнал өндөрлөх гээд байдаг. Гэтэл Д.Гантулга мэтийн өглөө босоод, ажилдаа цагтаа ирчихэж чадахгүй “бацаан”-ы оронд 60 дөхөж яваа чадвартай хүмүүс ажиллавал арай дээр биз дээ. Тэгээд Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч албанаасаа буугаад цэцэн үг хөөцөлдөж, шинэ нам байгуулж, хувийн компанид зөвлөх хийхгүй байх. Улс төрд буцаж ирж, гишүүн ч болж магадгүй. Ер нь тэр нь дээр байх. Гэхдээ Ерөнхийлөгч байсан хүн жижгэрлээ гэх тодотгол яах аргагүй дагана. Тиймээс л насны босгыг нь нэмчихье. 55 настай хүн Ерөнхийлөгч боллоо гэхэд дөрвөн жил суухад 60 хүрчихнэ. Хэрвээ улирвал 63 настайдаа бууна шүү дээ. Энэ зэргийн настай байхдаа улс төрөөс хөндийрч, ном зохиол бичиж, цэцэн үг цуглуулсан шиг суухад яах вэ дээ. Харин 45-тайдаа Ерөнхийлөгч болчихоод, 50 хүрээд л буухаар жаахан харамсалтай байна. Яах вэ, Ерөнхийлөгч байсан хүн улс төрд дахиж орж, гишүүн болж болохгүй гэсэн юм байхгүй л дээ. Гэхдээ л ёс зүй, утга учир талаасаа жаахан тиймхэн байгаа юм. Тиймээс аль аль талаа бодсон ч насны босгыг 10 жилээр нэмье. Залуучууд эхлээд бөгсөө зөв арчаад сурчихаг. Ядаж л гэр бүл, үр хүүхдийнхээ өмнө үүрэг хүлээгээд, өөрт оногдсон ачаагаа үүрэх чадвар суух. Түүний дараа ард түмний өмнө үүрэг хүлээж, улсын ачаа үүрэх бага ч болов тэнхээтэй болох учиртай.



# ЦАГ ҮЕ

ХУУЛЬ МЭНДЛЭХИЙН ӨМНӨ

# Б.ЭНХБАЯР:
## ХОРИХ ЯЛААС АЛЬ БОЛОХ ТҮДГЭЛЗСЭН



Засгийн газраас шинэ оны өмнөхөн УИХ-д Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийн төслийг өргөн барьсан, энэхүү төслүүдтэй холбогдуулж, ХЗДХЯ-наас боловсруулж, өргөн мэдүүлсэн хуулийн төслөө олон нийтэд танилцуулах зорилгоор "Хууль төрөхийн өмнө" сэдэвт хэлэлцүүлгийг өчигдөр зохион байгуулав. Энэ удаагийн хэлэлцүүлгээр ХЗДХЯ-наас боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцууллаа. Хэлэлцүүлэгт ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, Дэд сайд Б.Энхбаяр, Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, ХЗДХЯ-ны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд, Улсын Дээд шүүх, ШЕЗ, ШШГЕГ, Авлигатай тэмцэх газар, ТЕГ, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, эрдэмтэн судлаачдын төлөөлөл оролцов. Хэлэлцүүлгийн эхэнд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нөхцөлийн талаар тайлбарлав.

Тодруулбал, 2015 онд УИХ-аас баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь 440 гаруй заалттай бөгөөд 100 хувь шахам хорих ялтай байсан аж. Тиймээс зарим хөнгөн хэрэгт хорих ял ногдуулахгүй байхаар тусгаж, хорих ялын доод хугацаа долоо хоног байсныг зургаан сар болгож, үүнтэй уялдуулан нийтэд тустай ажил хийлгэх ялыг үндсэн ялд тооцон хэрэглэх нөхцлийг бүрдүүлжээ. 2015 оны шинэ Эрүүгийн хуульд нийтэд тустай ажил хийлгэх ялыг 440 заалтаас ердөө хоёрхон заалтад хэрэглэхээр заасан байсныг өргөтгөж өгсөн аж. Ингэснээр заалт бүрт хорих ял ногдуулахаар заасан байсан нь буурчээ. Мөн 2015 оны хуульд албан тушаалын гэмт хэрэгт ногдуулах ялын бодлого зөөлөн, зарим томъёолол нь гэмт хэрэгтний ял завшуулах боломж үүсгэсэн байсныг чангалж, учруулсан хохирол бүрт нь тохирсон ял оноохоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Түүнчлэн залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн хүн хохирлоо барагдуулбал гэмт хэрэгт тооцохгүй, ял шийтгүүлэхгүй байх зэрэг заалтууд туссан байсныг өөрчилж, ял авахаар зааж өгчээ.

ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт хэлэлцүүлгийг нээж, хэлсэн үгэндээ "Дээрх хуулиудыг боловсруулах, хэлэлцэн батлах болон батлагдсаны дараах шатанд иргэд болон тодорхой салбар, судлаачдаас багагүй хэмжээний санал, шүүмжлэл ирүүлж байсныг судлахад уг хуулийг практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд хүндрэл үүсгэх, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших, эсхүл түүний эрх зүйн байдлыг дордуулсан, олон төрлийн зөрчилтэй, хууль зүйн техник, утга найруулгын алдаатай зохицуулалт нэлээдгүй байна. Иймд хууль өөрөө цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, аливаа зөрчил, хийдэлгүй байх нийтлэг зарчимд тулгуурлан дээрх асуудлыг зохицуулах зорилгоор 2015 оны арванхоёрдугаар сарын 03, 04-ний өдрүүдэд УИХ-аас хэлэлцэн батлагдсан, 2017 оны долдугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүссэн. Эрүүгийн хуулийг батлах үед ч, батлагдсаны дараа ч энэ хуулийг хүний эрхийг хангахад дэвшил болсон, шоронжуулах, шоронд гэмт хэрэгтэн бэлтгэхээс зайлсхийсэн гэж ярьсан. Судлаад үзэхээр харамсалтай нь, тийм биш байсан. Жишээ нь, одоогийн үйлчилж байгаа 2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд бүх гэмт хэрэгт хорих ял ногдуулдаггүй. Үнэн хэрэгтээ нийт гэмт хэргийн гуравны нэг нь огт хорих ялгүй тийм л хууль одоо үйлчилж байгаа. Гэтэл түүнийг сайжруулж байгаа гэж ярьж байгаад баталсан 2015 оны Эрүүгийн хуулийн бүх гэмт хэрэгт хорих ял шийтгэхээр болчихсон байсан. 440 заалт гэмт хэрэг 100 хувь хорих ялтай байсан. Эсрэгээрээ жинхэнээсээ шоронжуулах бодлоготой хууль шинээр баталчихсан. Үүнийг хүний эрхийн тал дээр дэвшил гарсан гэж яагаад ч хэлэх аргагүй. Түүнчлэн практикт уг хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл үүсгэх боломжтой, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших, эсхүл түүний эрх зүйн байдлыг дордуулсан, хууль зүйн техникийн хувьд олон төрлийн хийдэл, зөрчилтэй, утга найруулгын алдаатай заалтууд байсныг залруулж байгаа. Ганцхан жишээ хэлэхэд залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн хүн хохирлоо барагдуулбал гэмт хэрэгт тооцохгүй, ял шийтгэхгүй гээд хуульчилсан байсан. Энэ нь залилагчид шалгагдаад, шүүхэд хэрэг нь ирэхэд нэгийг залилж нөгөөгийнхөө өрийг дараад л ял шийтгэгдэхгүй яваад байх боломжийг олгосон байсан" хэмээн онцлон тэмдэглэсэн юм.

Үүний дараа ХЗДХ-ийн Дэд сайд Б.Энхбаяр Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар ХЗДХ-ийн дэд сайд Б.Энхбаяр танилцуулга хийлээ. Тэрбээр "ХЗДХЯ-наас Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт хийж, хуулийн төслийг өргөн барьсан. Эрүүгийн хуулийг 2015 онд батлахдаа тусгай ангийн 440 заалт нь бүгд хорих ялтай болчихсон. Анх ярьж байсан үзэл баримтлалаасаа эсрэг хууль батлагдсан. Дотор нь задлаад үзэхээр хорих ял долоо хоногоос эхэлж байгаа юм. Хорих гэдэг бол хамгийн хүнд ял шийтгэл ногдуулж байгаа хэлбэр. Тэгэхээр шоронд сууна гэдэг долоо хоног, долоон сар ч бай ялгаагүй нэр төр, эрхэмсэг оршихуйд их халтай. "Энэ хүн долоохон хоног ял эдэлж байсан юм" гэж хэн ч ярьдаггүй. Насаараа л шоронд ял эдэлж байсан гэдэг нэртэй явна. Гэр бүл болох, шинэ ажилд орохоос эхлээд өнөөх ял шийтгэл эдэлж байсан гэдэг нь муу нэр салахгүй. Тиймээс Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа хорих ял шийтгэлээс аль болох түдгэлзэх, анх удаа үйлдсэн, хөнгөн гэмт хэрэгт заавал хорих ял ногдуулж, шорон гянданд хорихоос татгалзая гэж байгаа юм. Үүний оронд 60 гаруй зүйл анги дээр нийтэд тустай ажил хийлгэхээр оруулж өгсөн. Тодруулбал, өдөрт дөрвөөс ихгүй цаг ажил хөдөлмөр эрхлэх заалт бий. Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэлийг хэвээр хадгалж байгаа. Тодорхой төрлийн гэмт хэрэгт хатуу байр суурьтай байх, тэр дундаа авлига, албан тушаалын гэмт хэрэгт ялын бодлогыг чангатгана.Сүүлийн үед улс орны эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой саяаар биш тэрбум, их наядаар хэмжигдэх хохирол учруулсан албан тушаалын хэргүүд ихээр гарч байна. Үүнийг төр зүгээр хараад байх юмуу, жирийн нэг хулгайтай адилхан шийтгээд байх юмуу. Хатуу ял шийтгэл ногдуулж, төрийн алба хаших хугацааг хоёр жилээр хязгаарладаг байсныг нь таван жил болгож, чангаруулахаар заасан" гэв.

PHOTO NEWS





*Монгол Улсын Үндсэн хуулийн 25 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Үндсэн хуулийн уг эхийг Монгол төрийн түүхийн музейд хүндэтгэлтэйгээр залах ёслолын арга хэмжээ өчигдөр боллоо. 1992 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын анхны ерөнхийлөгч П.Очирбатын гарын үсэг зурж, батламжилсан эхийг, түүний хүндэтгэлийн гэр хайрцгийн хамтаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөөнөөс Монгол төрийн түүхийн музейд хүндэтгэлтэйгээр авчиран заллаа. Үндсэн хуулийн уг эхийг 2017 оны нэгдүгээр сарын 13-20-ны хүртэлх хугацаанд 10:00-17:00 цагийн хооронд олон нийтэд үзүүлэх ажээ.*

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

*Аймгаас мэдээлж байна*

ОРХОН АЙМАГ

### Малчдын өвөлжилтийн байдалтай 11 чиглэлд танилцана

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр малчдын өвөлжилтийн байдалтай танилцах ажлын хэсгийг байгуулсан билээ. Тус ажлын хэсгийг Засаг даргын орлогч С.Батжаргал ахлаж, бүрэлдэхүүнд нь ХХААГ, хоёр сумын МЭҮТ, БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нар зэрэг хэд хэдэн байгууллагын 40 төлөөлөл багтжээ. Ажлын хэсэг энэ сарын 5-аас эхлэж Баян-Өндөр, Жаргалант сумын 11 чиглэлд өвөлжилтийн байдалтай танилцаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж цаашид авах арга хэмжээний талаархи саналаа холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах юм байна. Одоогоор ажлын хэсгийн бүрэлдэхүүн энэ удаагийн явалтаар нийтдээ 900 гаруй айлаар орохоор төлөвлөөд байгаа аж. Мөн малчдын нөөцөлсөн өвс, тэжээлийн зарцуулалт, хэрэгцээний талаархи мэдээллийг нэгтгэхээс гадна малын тарга, хүч, хорогдол, бэлчээрт гарах боломжгүй болсон малын тоог гаргах аж. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хүн, малын эмч нар багтсан учир хот айлын хүн, малд үзлэг оношилогоо хийж, шаардлагатай зөвлөмж өгөх хэрэгтэйг ажлын хэсгийн ахлагч онцолж байна. Түүнчлэн малчдын нөөц шавхагдсан тохиолдолд өвс, тэжээлийг зах зээлийн үнээс хямд үнээр нөөцөөс олгохоор шийдвэрлэжээ. Ийнхүү ажлын хэсэг малчдын өвөлжилтийн байдалтай танилцсанаар Орхон аймагт зудын байдал үүссэн эсэхэд бодит дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг зөв тодорхойлох ач холбогдолтой хэмээн аймгийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга Д.Батлут үзжээ.



СЭЛЭНГЭ АЙМАГ

### Иргэдэд өмчлүүлсэн болон эзэмшүүлсэн газрын ашиглалтыг дахин хянахыг үүрэгдэв

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сарын 4-ний өдөр шинэ оныхоо анхны хуралдааныг хийж, хэд хэдэн асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Тухайлбал, тэргүүлэгчид өнгөрсөн 2016 онд нийтдээ 21 удаа хуралдаж, 116 тогтоол шийдвэр гаргасан байна. Энэ удаагийнхаа хуралдаанаар 2017 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг батлах тухай асуудлыг хэлэлцсэн байна. Сэлэнгэ аймгийн 17 сумын ИТХ-аар батлан гаргасан санал дээр үндэслэн аймгийн ИТХ-аас жил бүр тухайн онд иргэдэд өмчлүүлж, эзэмшүүлэх газрыг батлан гаргаж шийдвэрлэдэг журмын дагуу эл асуудлыг хэлэлцжээ. Ингэснээр иргэд 2017 онд аймгийн төлөвлөгөөнд тусгагдсан, ИТХ-аар батлагдсан газрыг өмчлөх, эзэмших эрх зүйн боломж бүрдэж байгаа юм. Хуралдааны үеэр аймгийн ИТХ-ын даргын зүгээс аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдэд хандаж 2016 онд иргэдэд өмчлүүлсэн болон эзэмшүүлсэн газрыг дахин хянаж, хэрхэн зөв зориулалттайгаар ашиглаж байгааг эргэн шалгах үүрэг өгчээ.

ХЭНТИЙ АЙМАГ

### "Малчиддаа туслах халуун сэтгэлийн тус" уриалга амжилттай хэрэгжиж байна



Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба нийт албан байгууллага, ААН, ард иргэдийн дунд "Малчиддаа туслах халуун сэтгэлийн тус" уриалга гарган тусламжийн аян өрнүүлсэн нь амжилттай хэрэгжиж байна. Тус уриалгыг төрийн болон төрийн бус байгууллага, ААН, ард иргэд талархан дэмжиж, зарим байгууллагууд нэгдэн сумдыг хуваарилан авч тусламжийн цувааг өвөлжилт хүндэрсэн сумдын малчдад хүргэсээр байна. Тухайлбал, энэ сарын 3,4-ний өдрүүдэд "Дэлхийн Зөн" ОУ-ын байгууллагын "Бор-Өндөр 2" Нутгийн хөгжлийн хөтөлбөрийн багийн хамт олон, аймгийн ЗДТГ-тай хамтран хөтөлбөр хэрэгждэг Өмнөдэлгэр, Хурх, Биндэр, Баян-Адрага сумдын нийт зорилтот бүлгийн 80 өрхийн малчдад 11,2 сая төгрөгийн өртөг бүхий малын тэжээл, будааг хүлээлгэн өглөө. Энэхүү үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга Н.Ганбямба, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, Төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, "Дэлхийн Зөн" ОУ-ын байгууллагын "Бор Өндөр 2" НХХ-ийн багийн ахлагч Г.Жаргалбат тэргүүтэй орон нутгийн удирдлагууд оролцсон байна. Мөн энэ үеэр Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын уугуул, өдгөө Улаанбаатар хотын Багануур дүүрэгт оршин суугч, өндөр настан н.Тунгалагийн чин сэтгэлийн хандив болгон илгээсэн дулаан хувцсыг малчдад хүргүүлэхээр сумын удирдлагуудад гардуулан өгчээ. Хэнтий аймгийн хувьд энэ жил цас эрт, их хэмжээгээр унасны улмаас нийт нутгаар өвөлжилт хүндэрч, зудын байдалд шилжин малчид, мал бүхий иргэд маань хатуухан өвөлтэй нүүр тулаад байна. Энэ байдлыг харгалзан үзэж, хатуу өвлийг хамтын хүчээр давж, урин хавартай мэнд золгоход нь бодит дэм болох үүднээс аймгийн Засаг дарга ийнхүү уриалга гаргасан ажээ.

# ОНЦЛОХ ХУУДАС

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХУУЛИЙГ УЛААН ГЭРЛЭЭР БАТЛАХЫН УЧИР...

## Эсрэг тэсрэг байр суурь



### Н.Энхболд: Ерөнхийлөгчийн сонгуулийн хуульд Үндсэн хууль зөрчсөн заалт байхгүй

*/УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга/*

...УИХ-д суудалтай нам Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ дэвшүүлнэ гэж заасан байдаг. УИХ-д суудалтай нам гэж хэнийг хэлэх вэ гэдгийг тодорхойлсон байдаг. УИХ-д суудалтай нам нь дангаараа нэг, нэг хүн дэвшүүлнэ үү, хамтраад дэвшүүлнэ үү чөлөөтэй. Энэ бүх эрх нь нээлттэй...

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг өргөн барьснаас хойш гүтгэлэг хэрээс хэтэрч байна УИХ-ын гишүүд хэлж, ярьж буй үгэндээ хариуцлагатай хандмаар байна. УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд ганцхан МАН хүнээ нэр дэвшүүлэх боломжтой байхаар хуулийн төслийг санаачлан өргөн мэдүүллээ” гэж мэдэгдэл хийн олон нийтийг бужигнууллаа. Монгол Улсын Үндсэн хуульд “Парламентад суудалтай улс төрийн хүчин Ерөнхийлөгчийн сонгуульд хүнээ нэр дэвшүүлнэ” гэж заасан. Энэ заалт тэр чигээрээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд суусан. Ерөөсөө Үндсэн хуульд заасан заалтуудыг хуулийн төсөлд тусгачихсан байхад л Үндсэн хууль зөрчсөн Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль өргөн барилаа” гэж тайлбарлаж байгааг ойлгохгүй байна. Хуулиа уншдаггүй юм уу, эсвэл хэргээр ингэж мушгиад байдаг юм уу. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд Үндсэн хууль зөрчсөн заалт байхгүй. УИХ-д суудалтай нам Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчээ дэвшүүлнэ гэж заасан байдаг. УИХ-д суудалтай нам гэж хэнийг хэлэх вэ гэдгийг тодорхойлсон байдаг. УИХ-д суудалтай нам нь дангаараа нэг, нэг хүн дэвшүүлнэ үү, хамтраад дэвшүүлнэ үү чөлөөтэй. Энэ бүх эрх нь нээлттэй. Нам бус хүнийг ч гэсэн зөвшөөрлийг нь авсан бол Ерөнхийлөгчийн сонгуульд дэвшүүлж болно гээд байж байгаа. Сурталчилгааны хугацаа өмнөх хуульд 18 хоног байсныг сунгаж, 22 хоног болгосон. Ингэснээр нэр дэвшигч бүртгүүлээд шууд сурталчилгаагаа эхлүүлэх боломжийг нээсэн. Ер нь бол суудалгүй намтай хамтраад нэр дэвшүүлсэн ч хорьсон юм байхгүй. Цаад нам нь дэмжээд л оролцоно биз. Хоёр нам нийлэхэд нэг л хүн нэр дэвшүүлнэ. Энэ хуульд Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь 45 нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан гэж, зургаан сараас дээш хугацаагаар гадаадад оршин суугаагүй гэж бичсэн нь, та нарыг өмнөх парламентад олонхи байх үед баталсан хуульд заасан заалт юм.



### О.Баасанхүү: Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн

*/УИХ-ын гишүүн/*

...Энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг. Монгол Улсын иргэн хүн хаана ч амьдарч байсан байж болно. Хоёрдугаарт, парламентад гуравхан нам ерөнхийлөгчид нэр дэвших бие даасан субьект байгаа. МАН, АН, МАХН. Гэтэл үүн дээр нэр бүхий намууд хамтран нэр дэвшүүлнэ гэсэн заалт оруулж ирж байгаа...

-Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч болох шалгуурыг тодорхой заасан. Тодруулбал, “45 нас хүрсэн байх ёстой, аль нэг намыг төлөөлөхгүй байх ёстой” гэж хатуу шаардсан байдаг. Гэтэл одоогийн өргөн баригдаад байгаа хуулиас харах юм бол нэгдүгээрт заавал өөрийн намын гишүүнээ дэвшүүлнэ. Хоёрдугаарт, нам бус байгаа бол тэр нам бус гишүүнээс зөвшөөрлийг нь бичгээр заавал авна гэсэн ийм заль оруулчихаад байгаа юм. Гэтэл энэ нь ерөөсөө сонгуулийн хуулийн тогтолцоотой харшилж байна. Тухайлбал, орон нутгийн сонгууль гэж байна. Тухайн орон нутагт зургаан сараас дээш заавал амьдарсан байх ёстой гэж заадаг. Парламентын сонгууль бол заавал өөр аль нэг намын гишүүнийг дэвшүүлж болохгүй. Яагаад гэвэл намууд мөрийн хөтөлбөрөөрөө өрсөлддөг учраас Монгол Улсын Ерөнхийлөгч бол тийм биш. Ерөнхийлөгч бол нийт ард түмнээс сонгогддог. Гэтэл өнөөдөр энэ хуулийн 6.3 дахь заалт дээр эсрэгээр нь тайлбарлачихсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад сүүлийн арван жил амьдарсан байх ёстой гэж. Энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг. Монгол Улсын иргэн хүн хаана ч амьдарч байсан байж болно. Хоёрдугаарт, парламентад гуравхан нам ерөнхийлөгчид нэр дэвших бие даасан субьект байгаа. МАН, АН, МАХН. Гэтэл үүн дээр нэр бүхий намууд хамтран нэр дэвшүүлнэ гэсэн заалт оруулж ирж байгаа. Тэгэхээр хоёр нам хоорондоо өрсөлдөнө гэсэн санааг хатуу тусгаад байгаа юм. Гэтэл цаана нь Монгол Улсад бүртгэлтэй 21 нам байна. Тэднийг дэмжиж ажиллаж болно гэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хэдий суудалгүй ч гэсэн танай нэр дэвшиж байгаа хүнийг дэмжиж байгаа шүү гэсэн хэвлэлийн хурал хийхээс өөр ямар ч оролцоо байхгүй. Гэтэл өнөөдөр суудалгүй намтайгаа эвсээд хэдэн ч нам хамтраад нэрээ дэвшүүлэх эрхтэй байх ёстой. Эрхийг нь зөрчөөд байгаа юм. Тийм учраас миний хувьд үүнийг эрс эсэргүүцээд байна. Аливаа зүйл нотлох баримттай буюу бас ярих зүйл маань үндэслэлтэй байх ёстой. Тухайлбал, үүн дээр хуулийн заалт байна. Энэ хуулийн заалт дээр 6.3-т 45 нас хүрсэн сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан гэсэн заалт. Таван жилийн дотор гадаад руу гарч болохгүй гэсэн санаа байна шүү дээ. Хоёрдугаарт 30.7 дээр Нэг намын гишүүнийг өөр намаас намууд хамтарсан тохиолдолд өөр намын гишүүн нэр дэвшихийг хатуу хориглоно. Тэгэхээр энэ бол заавал тухайн намын гишүүн байх ёстой гээд байна шүү дээ. Мөн 30.8 Нам аливаа нэгэн намын бус иргэнийг түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр нэрийг дэвшүүлж болно гэх зэрэг ийм утгагүй зүйл заалт нь юуг хэлээд байна вэ гэхээр ард түмнээ гурван сая иргэнээ намуудад хуваачихсан,Ийм утгагүй зүйл байж болохгүй. Мөн нэгдүгээр сард багтаан батлана гэж байгаа нь нөгөө 65-ын л гай шүү дээ. Монгол Улсад өнөөдөр дорвитой сөрөг хүчин байхгүй. Хэрвээ хүсвэл өнөөдрийн дотор Үндсэн хуулиа өөрчилж чадна. Өнөөдрийн дотор Ерөнхийлөгчийн сонгуулийг хийж чадахаар байгаа юм эрх бригчид.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### ХЭНД НЭГЭНД ЗОРИУЛАГДСАН ХУУЛЬ БАТАЛЧИХ ВИЙ

Ж.ОТГОН

УИХ дахь олонхийн бүлэг шинэ оны анхны хуралдаанаараа Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж, энэ сардаа багтаан шинэчлэн батлахаар “ханцуй шамлан” ороод буй. Улс төрийн том, жижиг намуудын анхаарлыг татсан энэ асуудал аль хэдийнэ “хэрүүлийн алим” болчихоод байгааг ард түмэн ч мэдэж байгаа. Ерөнхийдөө улстөрчид аливаа сонгуулийн өмнө хуульд өөрчлөлт оруулдаг нь бараг “мода” болон дэлгэрсэн гэхэд чхилсдэхгүй. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль ч үүнийг тойрсонгүй дайраад өнгөрөх нь тодорхой боллоо. Угтаа бол Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг УИХ-ын гишүүн Н.Энхболд тэргүүтэй хэдэн гишүүн УИХ-ын даргад өргөн бариад байгаа юм. Тэгвэл энэхүү хуулийн талаар СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Хуульд зарчмын чанартай томоохон өөрчлөлт ороогүй. Том өөрчлөлт гэвэл нэгдсэн хуулиасаа Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг салгаж, бие даасан хууль болгож байгаагаараа онцлогтой” хэмээн мэдэгдсэн бол хуулийн төслийг санаачлагчдын нэг болох Н.Энхболд гишүүн “СЕХ-ноос бүх сонгуулийг нэг хуулиар зохицуулах нь төвөгтэй байна. Тиймээс тусдаа хуультай болох нь зүйтэй гэдэг саналыг Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн. Ингэхдээ 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд суурилж саналаа ирүүлсэн. Харин Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нэгдүгээр сарын дунд үед багтаад, Ерөнхийлөгчийн сонгууль болох хугацаа товыг зарлах зорилготой байгаа.

Энэ төслийг МАН-ын бүлэг дэмжсэн” гэдгийг дуулгаадахав. Тэдний хэлж буйгаар Сонгуулийн ерөнхий хороо л сонгууль явуулахад төвөгтэй байна гэж “гоншигоносон” болохоор л Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батлахаар төлөвлөөд байгаа гэж тайлбарлаад буй. Харин МАН-ын гишүүдээс бусад нь СЕХ-ны саналыг чих зөөлөн хүлээн авч хуулийн төсөл боловсруулан батлахаар улайрч байгаагийн цаана өөр шалтгаан байгаа хэмээж буй юм. Мэдээжийн хэрэг шүү дээ. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийг хэдхэн сарын өмнө өөрчилж, сонгууль хийх гэж байгаа нь ямар нэгэн байдлаар эрх баригчид өөрсдөдөө таатай хуулийн орчин бий болгох гэж байгаа нь ойлгомжтой. Тиймээс ч “Уг хууль нь Ерөнхийлөгчийн сонгуульд зөвхөн МАН-аас л хүн нэр дэвших эрхтэй болох нь” гэж УИХ-ын гишүүн О.Баасанхүү эсэргүүцээд байгаа биз. Харин УИХ-ын гишүүн Л.Болд “Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга гээд олон хуудас хууль орж ирсэн байна. Уг хуулийн төслийг тусад нь оруулж ирээд, зургаан сарын өмнө дахиад өргөн бариад байгаа. Энэ олон хуудас төсөл дотор юу ч оруулчихсан байгаа юм билээ гэсэн хардлагууд ард түмэнд байна. Энэ хуулиндаа итгэхгүй, энэ хуулиар явсан сонгуульдаа итгэдэггүй. Ингэх юм бол эрх баригчдын хувьд алдаатай бодлого болно гэж хараад байна. Бидэнд юу гэж тайлбарласан гэхээр бага зэргийн өөрчлөлт байгаа гэж хэлсэн.

Гэтэл яаравчилсан байдлаар том хууль оруулж ирээд батлахаар, сонгууль хуульд бүдрээд, дараа нь ард түмний итгэл үнэмшлийг авч чадахгүй байдал үүснэ. Битгий ийм байдалд хүрээсэй гэж миний хувьд үзэж байгаа. Гэхдээ олонхиороо шийдэх байх” гэдгийг хэлсэн. Харин УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж “Парламентад суудалгүй намуудын Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох байр, суурийг тодорхой болгох ёстой. Энэ талаар бид өргөн хэлэлцэх ёстой. УИХ-ын гишүүд уншиж ч амжаагүй байтал ийм том хуулийг батлуулах нь маш аюултай. Улс төрийн тогтвортой байдлаа хадгалах үүднээс уг хуулийг харилцан зөвшилцөж батлах шаардлагатай” гэлээ. Түүнчлэн эрх баригчдын тайлбарлаад байгаа шиг бага зэргийн өөрчлөлт орсон биш гэдгийг УИХ дахь АН-ын бүлгийн гишүүд дуулгалаа. Тодруулбал, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад өмнөх хуулиас 94 заалтыг өөрчилж, 100 орчим зарчмын зөрүүтэй саналыг оруулсан гэнэ. Энэ бүхнээс харж байхад О.Баасанхүү гишүүний хэлсэнчлэн 65-ын гайгаар хэн нэгэнд зориулагдсан хууль мэндлэх гэж байж ч болзошгүй байдал үүсээд байна. Ямар ч байсан эрх баригчид хуульд дур мэдэн гар хүрч, өөрсдөдөө зориулсан хууль баталчихвал эцсийн дүндээ хэн хохирч үлдэх нь ойлгомжтой биз ээ. Тэгээд ч сонгууль бүхний өмнө “хууль засдаг” байдал нь хэн нэгний эрх ашигт нийцүүлдэг гэдэг нь хэдийнэ тодорхой болчихсон шүү дээ.



### Ц.Нямдорж: Сонгуулийн хуулийг Үндсэн хуулийн хүрээнд оруулж ирж байгаа

*/УИХ-ын дэд дарга/*

-Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийг Үндсэн хуулийн хүрээнд оруулж ирж байгаа. УИХ-ын гишүүн О.Баасанхүү, С.Жавхлан нарын яриад байгаа асуудлын тухайд УИХ-д суудалтай нам л Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй. Үүнийг өөрчилье гэвэл Үндсэн хуульд гар хүрч таарна. Үндсэн хуульд гар хүрэхгүйгээр ганц шийдэх боломж бол нэр дэвших сонирхолтой хүн нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх боломжтой намд л элсэх боломж бий.



### С.Жавхлан: Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн эсрэг Хамаг Монголоороо тэмцэх болно

*/УИХ-ын гишүүн/*

-Хоёр эрх баригч нам ялангуяа МАН Ерөнхийлөгчийн сонгуульд хүч түрэн оролцох юм бол нийгэмд маш том хагаралдаан үүснэ. Үүнийг би төсөөлж байна. Харж байна. Манай сонгуулийн тогтолцоо сонгоё гэсэн зөв сэтгэлтэй хүмүүсийг нь шигшиж гаргаж ирэх тогтолцоо байдаггүй. Эс хүссэн ч хүссэн ч энэ нөхрийг л сонго гэсэн тогтолцоо яваад байгаа учраас түмэн олон залхаж, бухимдаад байгаа юм. Энийг өөрчлөх талаар хөндвөл Үндсэн хуулийг хүртэл өөрчлөх хэрэгтэй байгаа юм. Намайг энэ асуудлыг хөндөхөөр Жавхлан нэр дэвших гэж байна гэж хараад байх шиг. Гэхдээ яагаад бие даагчийн орон зайнаас ямарваа нэгэн хүнийг сонгуульд нэр дэвшүүлж болдоггүй юм бэ. Жавхлангийн байр суурь хасагдчихаар намайг сонгосон 70 мянган хүмүүс сонголтоо яаж хийх юм. Цаашлаад Монголын тал нутгаар намайг дэмжиж байсан олон хүмүүс байгаа ш дээ. Тэд нар сонгуульдаа яаж оролцох юм. Би “Хамаг Монгол”-ыг дуугаараа нэгтгэсэн шигээ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн эсрэг Хамаг Монголоороо тэмцэх болно.

# ДЭЛХИЙ

# БРАЗИЛД
## 100 гаруй ялтан амь үрэгдлээ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Гэхдээ өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа талаархи мэдээлэл тодорхойгүй байгаа юм. Ерөнхийдөө он гарснаас хойш тус улсад гурван ч удаа шоронд үймээн дэгдсэн байдаг. Эхний удаад Мануас хотын шоронд шинэ оны анхны өдөр буюу нэгдүгээр сарын 1-нд дээрх хоёр бүлэглэлд харъялагддаг ялтнууд маргалдан хоорондоо зодолдсоны улмаас 56 хүн толгойгоо хирчүүлсэн байдалтайгаар алагдсан юм. Энэ хэрэг "Анисио Иобим" гэх шоронд гарсан байдаг. Үймээн 17 цагийн турш үргэлжилж, энэ үеэр 112 хоригдол оргосон бол мөн ойролцоо байрлах шоронгоос ч 72 хүмүүжигч оргосны 40-ыг нь баривчилсан удаатай. Үймээний явцад шоронгийн 12 хуягийг хоригдлууд барьцаалсан боловч хуягууд ямар нэг шарх, гэмтэлгүйгээр мултарч чаджээ.

Үүний дараа буюу нэгдүгээр сарын 6-нд мөн шоронд үймээн гарсан юм. Бразилын хойд хэсгийн Рорайма мужийн Боа Виста гэх хотод байрлах шоронд мөн л ялтнууд хоорондоо зодолдсны улмаас 31 нь амьсгал хураажээ. Ийнхүү 2017 он гарснаас хойш Бразилын шоронд гурван ч удаа үймээн гарч, 100 гаруй ялтан амь үрэгдээд байна. Өмнө нь шоронд ийм тооны хүн амиа алдсан тохиолдол гарч байгаагүй аж. Өөрөөр хэлбэл, энэ удаагийн тохиолдол түүхэн дэх хамгийн олон хоригдол ял эдэлж байхдаа амиа алдсан тохиолдол болж байна.



## Японы Элчин сайд Сөүлийг түр хугацаагаар орхилоо

Дэлхийн II дайны үед Японы Эзэн хааны армийн цэргүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан солонгос эмэгтэйчүүд буюу "зугаацуулагч эмэгтэйчүүд"-ийн дурсгалд зориулсан хөшөөг Бусан хот дахь Японы Ерөнхий Консулын газрын өмнө талд байрлуулсныг холдуулахаас Сөүл татгалзсантай холбоотойгоор Япон улсаас Өмнөд Солонгост суугаа Элчин сайд Ясүмаса Нагаминэ, Ерөнхий Консул Ясүхиро Моримото нар өчигдөр эх орон руугаа тодорхойгүй хугацаагаар буцлаа. Уг хөшөөг Өмнөд Солонгосын иргэний нийгмийн нэгэн байгууллага өнгөрсөн арванхоёрдугаар сарын сүүлчээр Японы Ерөнхий Консулын газрын өмнө байрлуулсан юм.

Үүнтэй холбоотойгоор Япон улс Элчин сайд болон Ерөнхий Консулаа Өмнөд Солонгосоос эгүүлэн татаж, валют солилцох асуудлаарх хэлэлцээг зогсоож байгаагаа өнгөрсөн баасан гарагт мэдэгдсэн билээ. Элчин сайд Ясүмаса Нагаминэ, Ерөнхий Консул Ясүхиро Моримото нар Сөүлийн нисэх онгоцны буудлаас эх орон руугаа нисэх үедээ "Зугаацуулагч эмэгтэйчүүдийн хөшөөг босгосонд туйлын харамсч байна" гэж хэлжээ. Тэд хэр хугацаагаар нутаг буцах нь тодорхойгүй байгаа ч, долоо хоногоор явах болов уу гэх албан бус мэдээлэл байна. Энэ явдалтай холбоотойгоор Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээр өрнөх бөгөөд Гадаад хэргийн сайд Фүмио Кишида Сөүлийн талтай хэлэлцээр хийх гэнэ.

## Ким Кардашианыг дээрэмдсэн хэрэгт 16 хүнийг баривчилжээ

АНУ-ын реалити шоуны од Ким Кардашиан өнгөрсөн жил Францын Парис хотод загварын долоо хоногт оролцохоор очих үедээ дээрэмдүүлж, есөн сая орчим еврогийн үнэ бүхий үнэт эдлэлээ алдсан юм. Тэгвэл Францын цагдаа нар эл хэрэгт 16 хүнийг сэжиглэн баривчилсан талаар өчигдөр мэдээллээ. Хэрэг өнгөрөгч аравдугаар сард гарсан. Реалити шоуны од бүсгүй эгч, дүүсийнхээ хамтаар Францын загварын долоо хоногт оролцохоор Парист очсон байдаг. Улмаар түрээсэлсэн орон сууцандаа ганцаараа байхдаа дээрэмдүүлсэн билээ. Дээрэмчид хоёулаа байсан бөгөөд тансаг зэрэглэлийн түрээсийн орон сууц руу нэвтэрснийхээ дараа унтлагын өрөөнд нойрсож байсан Кимийн цохонд буу тулгаж, гар хөлийг нь баглан угаалгын өрөөнд түгжиж, дараа нь бүхий л үнэт эдлэлийг нь хамж одсон байдаг. Ким Кардашианы хувьд халдлагад өртсөнийхөө дараа хэвлэлд ямар нэг ярилцлага өгөөгүй юм. Харин саяхан нэгэн нэвтрүүлэгт оролцох үедээ дээрэмдүүлэх үеийнхээ талаар дурсч, алуулж ч мэдэх байснаа нулимс дуслуулан ярьсан нь бий.


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017.01.09
**Тендер шалгаруулалтын нэр:** "Цэцэрлэгийн барилга, 150 ор /Завхан, Тэлмэн сум/"
**Тендер шалгаруулалтын дугаар:** ХСХБУ-2016-003

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам эрх бүхий тендерт оролцогчдоос "Цэцэрлэгийн барилга, 150 ор /Завхан, Тэлмэн сум/" ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /Нэг зуун мянга/ төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болох ба Тендерийн баримт бичгийн төлбөрийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн сан дахь 900015003 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь 600,000,000.00 /Зургаан зуун сая/ төгрөгөөс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 300,000,000 /Гурван зуун сая/ төгрөгөөс багагүй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил /2014, 2015/-ийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудад доод тал нь нэг удаа 600,000,000.00 /Зургаан зуун сая/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**
- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт,
- 2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (1-5 давхар хүртэл)
- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт,
- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт (хуучнаар 2.2.2, 2.2.4, 2.2.9)
- 2.2.3. Ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт
- 2.2.4 Дулааны болон усан хангамжийн гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт
- 2.2.8 Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистраль/ шугам /35 кВ хүртэл/ угсралт эсвэл Эрчим хүчний яамны 3.2.3. 0.4-35 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ

Тендерийн хамт 15,000,000.00 / Арван таван сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 20 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно**

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал"-ын дагуу тооцно."

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Засгийн газрын III байр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, 5 дугаар давхар 516 /б/ тоот.**
**Санхүү, эдийн засгийн газрын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Л.Отгонжаргал.**
**Утас: 11-320358**


## Ираны Ерөнхийлөгч асан таалал төгсчээ

1979 оны Ираны хувьсгалд гол үүрэг гүйцэтгэж, УИХ-ын дарга, Ерөнхийлөгч гэх мэт төрийн чухал албан тушаалд томилогдож явсан Акбар Хашеми Рафсанжани зүрхний шигдээс өвчний улмаас 82 насандаа таалал төгсчээ. Тэрбээр хэдэн арван жилийн турш Ираныг тэргүүлж, улс төрд хүчин зүтгэж байсан юм. Рафсанжани ахмад номлогч, лалын хувьсгалын гол тулгуур багана төдийгүй гарамгай улс төрч байлаа. Тэрээр Тегераны эмнэлэгт таалал төгсчээ. IRNA агентлагийн мэдээлснээр Засгийн газар гурав хоногийн гашуудал зарлаж, өнөөдрийг бүх нийтийн амралтын өдөр болгон зарлаж, оршуулгын ёслолыг зохион байгуулахаар болсон байна.

Акбар Хашеми Рафсанжани 1934 оны наймдугаар сарын 25-нд Ираны өмнөд этгээдийн чинээлэг гэр бүлд төрсөн байдаг. Улмаар шийтийн урсгалын "Ком" гэх шашны сургуульд суралцсаныхаа дараа 1963 оноос улс төрд оржээ. Лалын шашны шийтийн урсгалын гол номлогч байсан тэрээр хичээл зүтгэлийнхээ үр шимээр УИХ-ын дарга болж, 1989 оныг хүртэл хоёр ч удаа улиран сонгогдсон байна. Харин 1989 онд Ерөнхийлөгчөөр сонгогджээ. Ингэхдээ 1997 оныг хүртэл хоёр ч удаа улиран сонгогдож, улсдаа шинэчлэл, хувьсгал хийсэн байна. Түүнчлэн, Арабын орнуудтай харилцаагаа сайжруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Мөн 2005 онд Ерөнхийлөгчид дахин нэр дэвшсэн ч, Махмуд Ахмадинежадад ялагдсан байна. Үүний дараа шинэ Ерөнхийлөгчийг чиглэсэн эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөж, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд дахин нэр дэвшсэн ч, өндөр настай гэх шалтгаанаар бүдэрч байжээ. Гэхдээ өнөөгийн Ерөнхийлөгч Хассан Руханиг идэвхитэй дэмжиж, ялахад нь чухал үүрэгтэй оролцжээ.

## "Fiat Chrysler Automobiles" АНУ-д 2000 ажлын байр шинээр бий болгоно



Европын машин үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч "Fiat Chrysler Automobiles" компани АНУ-ын хоёр үйлдвэртээ 2020 он хүртэл нийт нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 2000 хүнийг шинээр ажлын байраар хангах болсноо мэдэгдлээ. Тус улсын шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Доналд Трамп цагаачдын эсрэг хатуу бодлого баримтлахаас гадна дотоодын ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийг сэргээх чиглэлээр ажиллана гэдгээ сурталчилгааныхаа үеэр илэрхийлсэн. Улмаар энэ хүрээнд машин үйлдвэрлэгчид Мексикт хөрөнгө оруулалт хийж буйг шүүмжилсэн удаатай.

Тодруулж хэлбэл, саяхан өөрийн твиттер хуудастаа "Японы Тоёота корпораци Королла машиныхаа үйлдвэрийг Мексикт байгуулж буйг шүүмжлээд, нэг бол АНУ-д шилжүүл, эсвэр гаалийн өндөр татвар ногдуулна" хэмээн жиргэж сүрдүүлсэн удаатай. Мөн GM зэрэг компаниудыг шүүмжилснээр Форд Мотор ч Мексикт шинээр үйлдвэр байгуулахаа зогсоохоор болсон юм. Тэгвэл FCA тус жиргээтэй холбоотой юу, ямартай ч АНУ-ын Мичиган мужийн Детройт хотод зохион байгуулагдсан олон улсын авто шоуны үеэр ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөгөөнийхөө талаар мэдэгджээ. Ингэхдээ тэд Мичиган болон Охио мужид байрлах хоёр үйлдвэртээ нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, мөн тэндээ шинээр ажлын байр бий болгох гэнэ.


Зар Зар Зар

**Цэнгэлдэхийн хажууд "Хүрд"-ын байранд 1 өрөө байр зарна.**

**Утас: 96689101**

ЦАГ ҮЕ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт



# АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТЕХНОЛОГИ ТӨСЛИЙН ЗУУХААР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ

Өөрөөр хэлбэл, нийслэлчүүд болон төрийн удирдлагууд нүүрс,утаагүйзуухтайзууралдсаар байтал агаарын бохирдол гамшигийн хэмжээнд хүрчихэж. Тиймээс төр засгийн удирдлагууд агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан шат дараатай ажлыг хийж эхэлжээ. Тодруулбал, өчигдөр Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимд “Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” технологийн үзэсгэлэн нээлттэй боллоо. Энэхүү технологийн үзэсгэлэнг Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Агаарын бохирдлын үндэсний хороо, НЗДТГ-ын Агаарын бохирдлыг бууруулах газар, Улаанбаатар цэвэр агаар төсөл хамтран зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалан, Эрчим хүчний сайд П.Ганхүү, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол болон 50 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид оролцон өөрсдийн технологийг танилцууллаа. Үзэсгэлэнгийн үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Гэр хорооллын утааны асуудлыг бид олон жил ярьлаа. Манай Засгийн газар хөрөнгө, санхүүгийн боломж, бололцоо хомс байгаа хэдий ч агаарын бохирдолт ард иргэдийн эрүүл мэндтэй холбоотой учраас тодорхой шийдвэртэй арга хэмжээг авч, хэрэгжүүлэхгүй бол цаашид нийслэлийн утаа гамшгийн хэмжээнд хүрэх нөхцөл нь бүрдчихсэн. Зарим хүмүүс шөнийн тарифыг тэглэлээ. Энэ асуудлыг ямар байдлаар, яаж шийдвэрлэх юм гэж ярьж байна. Бид эхний ээлжинд шөнийн тарифаа тэглүүлэх нөхцөл бололцоог хангасан айл өрхүүдийн шөнийн тарифыг тэглэж байна. Нэг айл ч гэсэн өдөрт хоёр хувин нүүрс түлдэг байсан бол нэг хувин нүүрс түлээд 24 цагийг авдаг байх бололцоог л бүрдүүлэх ажлыг хийж байгаа юм.

Мэдээж хэрэг утааг бүрэн арилгана гэж хэлэхэд хэцүү шүү дээ. Үүнийг багасгахаас өөр арга байхгүй. Дэлхий дээр нийт 100 гаруй улсын 3000 хотод утаа, агаарын бохирдлын асуудал яригдаж байна. Түүний нэг нь Улаанбаатар хот. Гэхдээ сүүлийн жилүүдэд зөвхөн Улаанбаатар гэлтгүй зарим, аймгуудад ч утааны асуудал бий болсон. Эндээс үзэхэд агаарын бохирдол улс, орны хэмжээний асуудал болсон нь харагдаж байгаа юм. Засгийн газрын зүгээс ажил авсныхаа дараахнаас эхлээд Цэвэр агаар сангийн өрийг төлж эхэллээ. Засгийн газарт ямар ч мөнгө байхгүй. Олсон жаахан мөнгөөрөө бодсон санасан ажлаа хийчихье гэх боломжгүй л Засгийн газар өнөөдөр ажиллаж байна. Гэхдээ бид зах зухаас нь өрөө төлж байна. Өрөө төлчихвөл Цэвэр агаар сангийн хүрээнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээг шөнийн тарифыг тэглүүлэх ажил руу чиглүүлнэ. Мөн утаанаас салахад айл бүрийн оролцоо чухал. Монгол Улсын иргэн бүрийн оролцоо хэрэгтэй. Миний утсанд өдөрт агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой 100 гаруй мессэж ирж байна. Эдгээр хүмүүс өөрсдөө ч гэсэн санаачилгатай байж агаарын бохирдлыг бууруулахад ард, иргэдээ уриалах хэрэгтэй. Зөвхөн Засгийн газар, Ж.Эрдэнэбат зүтгэх биш. Бид өөрсдийн үүрэгт ажлаа хийнэ. Гэтэл иргэд өөрсдөө санаачилгагүй байх юм бол хурдан хугацаанд утааны асуудлыг шийднэ гэхэд хэцүү. Тийм учраас иргэд санаачилгатай байх хэрэгтэй” гэв. Үүний дараа Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатүзэсгэлэндоролцогч, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, сонирхсон юм. Уулзалтын дараа Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” технологийн үзэсгэлэнд оролцсон 50 гаруй аж ахуйн нэгжийн удирдлагуудыг энэ сарын 12-нд Төрийн ордонд хүлээн авч, уулзан Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх саналыг гаргах ажээ.

## Уурын зуухыг халсан технологийн дэвшил

Урд яваа машин алгуурхан сааралтсан утаан дунд уусан алга болж, гадаа гудамжинд тавхан минут алхахад угаарын үнэр үс хувцсанд шингэж, хүүхдийн эмнэлгийн ачаалал хэтэрсэн ч бид нүд нь балай, чих нь дүлий юм шиг явсаар байсан гэхэд хилсдэхгүй. Агаарын бохирдол нүдний өмнө илт ихсэж байхад амаа үдүүлчихсэн хүн шиг нөгөө л нүүрс, утаагүй зуухаа ярьсаар байсан. Нэг үгээр хэлбэл, нүүрс, утаагүй зуухнаас өөрийг сэтгэхгүй хайрцаглагдчихсан байсан гэхэд болно. Гэвч инженер, технологийн эрдэмтэд цахилгаан бага зарцуулдаг чийдэнгээс эхлээд уурын зуухыг халсан технологийг зохион бүтээж, зарим нь худалдаанд гаргажээ. Агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын утааг багасгах, цахилгаанаар дулаанаа хангах зорилго бүхий энэхүү үзэсгэлэнд оролцож буй компанийн нэг бол “Ховд Тул” компани юм. Тус компани ижил цэнэгтэй ионуудын түлхэлцлийн хүчний үйлчлэлээс дулаан үйлдвэрлэдэг овор хэмжээ бага, зай талбай эзлэхгүй, дуу чимээгүй, эрчим хүчний хэмнэлттэй халаалт болон халуун усны асуудлыг шийдсэн “Цэнэгт ус” төхөөрөмжийг бүтээжээ. Энэ талаар тус компанийн захирал Д.Басандорж “Маш олон төрлийн технологиуд бий. Гэхдээ ихэвчлэн цахилгаанаар халаадаг тэнь байдаг. Энэ бүтээгдэхүүн хэрэглээнд нэвтэрсэн. Бид төхөөрөмжийнхөө туршилтыг ШУТИС-тай хамтран хийсэн. Өнгөрсөн жил таван газрыг уурын зуухыг зогсоосон. Тэгэхээр агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хэмжээнд хувь нэмрээ оруулж байгаа юм. Бид ихэвчлэн сургууль, цэцэрлэгийн халаалтыг асуудлыг шийдсэн. Тухайлбал, Сүхбаатар дүүргийн 166, Чингэлтэй дүүргийн 154, 1733, Сонгинохайрхан дүүргийн Тахилтын цэцэрлэг, Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн нүүрсээр ажилладаг уурын зуухыг зогсоож, уснаас дулаан үйлдвэрлэх төхөөрөмж тавьсан. Сургууль, цэцэрлэгийн халаалтын системд улсын төсвөөс 64 тэрбум төгрөг суусан байдаг. Энэ төхөөрөмжийг хэрэглэвэл 37 тэрбум төгрөг зарцуулах боломжтой. Хэмнэсэн мөнгөөрөө шин сургууль, цэцэрлэг барьж болно. Ийм боломж, бололцоо бий” гэв. Уг төхөөрөмж нь өдөрт 10-20 кВт цахилгаан энерги буюу 1300-2600 төгрөгийн зардал гаргадаг байна. Мөн 5-20 литр ус зарцуулах боломжтой аж. Энэ бол тус үзэсгэлэнд дэлгэгдсэн энгийн наад захын жишээ. Албан байгууллага гэлтгүй айл өрхүүд хэрэглэж болохуйц үнийн хувьд боломжийн төхөөрөмж, бүтээгдэхүүн энд олон байлаа.

## Хуш модны самрын ясаар шахмал түлш үйлдвэрлэжээ

Намрын улирал эхлэхтэй зэрэгцээд гудамж талбайд хөглөрч хэвтдэг самрын яс нийслэлчүүдийн толгойны өвчнийг анагаах бас нэгэн шийдэл болон үзэсгэлэнгийн ширээнд заларчээ. Товчхон хэлэхэд, Тара компани 2008 оноос эхлэн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд одоогоор дөрвөн төрлийн шахмал түлш гаргаад байгаа аж. Модны үртэс, самрын яс, хаягдал цаас, хаягдал тосноос шахмал түлш гаргаж авдаг байна. Эдгээр түлш байгалийн гаралтай учраас хүхэрлэг хий гаргадаггүй гэнэ. Харин үнийн хувьд 25 кг нь 4000, 35-40 кг нь 9-10 мянган төгрөг аж. Үртсэн шахмал түлшийг хэрэглэхдээ нэг удаад гурван ширхэг хийх бөгөөд 40-50 минут дулаанаа хадгалах чадвартай юм байна. Түүнчлэн тус компани шахмал түлшээ асаах гал асаагчийг хүртэл модны үртэс ашиглан хийжээ. Энэхүү асаагч гурван ширхэг нь 500 төгрөгийн үнэтэй, нийт 12 удаа гал асаах боломжтой гэдгийг “Тара” компанийн ажилчид онцлов. Энэ мэтчилэн гэр хорооллын утааг багасгах үүрэгтэй олон бүтээгдэхүүн, төхөөрөмж үзэсгэлэнгийн танхимыг дүүргэжээ. Зах зухаас нь дурьдвал, зургаан давхар эсгийтэй тэнцэхүйц гэрийн цахилгаан дулаалга, хаявч, хөшиг, халаалтын төхөөрөмж, тортог шүүгч, цахилгаан бага зарцуулдаг чийдэн, дулаан хадгалагч гээд утааг бууруулах төхөөрөмж төслийн зуухаар хязгаарлагдахгүй гэдгийг илтгэж байв.

## Монгол гэрт зориулсан эко төхөөрөмжийг лизингээр авах боломжтой



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо” технологийн үзэсгэлэнгийн нэг онцлох бүтээгдэхүүн нь “Монватт” компанийн үйлдвэрлэсэн монгол гэрт зориулагдсан дулаан хуримтлуулж, халаах эко “Тулгат” төхөрөөмж юм. Энэ үеэр тус компанийн инженерүүд “Өвлийн улиралд үүсч байгаа утааны 70 орчим хувийг нийслэлийн гэр хорооллоос гарч байгаа утаа эзлэж байна. Улаанбаатар хотын есөн дүүргийн гэр хороололд нийт 194 мянган айл өрх гэрт, 106 мянган айл өрх амины орон сууцанд амьдарч байна. Манай компани хүйтэн сэрүүний улирлын найман сарын хугацаанд шөнийн 8-9 цагийн эрчим хүчийг ашиглан дулаан хуримтлуулж, халаах “Эко төхөөрөмж” бүтээсэн. Энэхүү төхөөрөмж нь 8-9 цагийн дотор хуримтлуулсан дулаанаа хоногийн үлдсэн цагт буцаан үлээж гэрийг тогтмол хэмийн дулаантай байлгадаг. Бид энэ төхөөрөмжөө 2015 онд туршилтын журмаар үйлдвэрлэлд оруулж, 2016 онд 81 ширхэгийг айл өрхөд суурилуулж үзсэн. Хэрэглэгчдийн зүгээс их таашааж байсан. Мөн манай компани энэ онд 25 мянган ширхэг төхөөрөмжийг оруулж ирэн зорилтот зах зээлд нийлүүлэхээр ажиллаж байгаа. Бидний хийсэн тооцооллоор энэ арга хэмжээний үр дүнд гэр хорооллоос ялгарах утааг 28.4 хувиар бууруулна гэж үзэж байгаа. Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэгчдэд хүргэхэд тулгарч байгаа гол асуудал нь ард иргэдийн худалдан авах чадвар юм. Санхүүгийн бэрхшээлээс гарах асуудлыг компанийн зүгээс зохих хэмжээнд шийдвэрлэхийг эрмэлзэж байгаа. Тухайлбал, хамтран ажиллаж байгаа Германы тал өөрийн улсынхаа арилжааны банкнаас урт хугацааны хоёр хувийн хөнгөлөлттэй зээлийг авч өгөхөөр санал болгосон. Энэ зээлийг иргэдэд дарамт шахалтгүй, зээлийн хүүг ирсэн нөхцөлөөрхүргэхталаароновчтой санхүүгийн механизм хэрэгтэй байгаа юм. Бидний судалгаагаар монгол гэрт амьдарч байгаа иргэд түлээ, нүүрс, хогонд сар бүр 120-125 мянган төгрөг зарцуулдаг. Тэгэхээр иргэд энэ хэмжээний мөнгийг сар бүр банкинд тушаагаад байхад хоёр жилийн хугацаанд 38 жил хэрэглэх евро стандартын шаардлага хангагдсан өндөр технологийн төхөөрөмжтэй болох боломжтой. Одоо бидэнд төр засгийн зүгээс зөв менежменттэй ухаалаг бодлогын туслалцаа хэрэгтэй байна” хэмээсэн юм. Харахад, дуковон пелетькатай адилхан энэхүү төхөөрөмжийг ажиллуулахад нүүрс, түлээ хэрэглэх шаардлагагүй юм байна. Мөн уг төхөөрөмжийг хэрэглэснээр нүүрс түлээнээс 125 мянган төгрөг, цахилгаанаас 46 мянган төгрөг хэмнэх боломжтой аж. Ингэснээр жилд нэг сая 368 мянган төгрөгийн хэмнэлт гаргана гэдгийг тус компанийн инженерүүд онцолж байв. Харин эко төхөөрөмжийн үнэ хоёр 400 мянган төгрөгийн үнэтэй бөгөөд “Монватт” компанийн зүгээс иргэдэд 1.5-2 жилийн хугацаатай 3-5 хувийн хүүтэй зээл олж, өгч дэмжихийг төрийн удирдлагуудад тавьж байгаа ажээ.

МЭДЭЭЛЭЛ

## Хотын дарга захирамж гаргав

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд өчигдөр захирамж гаргалаа. Уг захирамжийнхаа талаар тэрбээр “Өнөөдөр агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нийслэлийн Засаг даргын зүгээс гурван захирамж гаргасан. Өнгөрсөн оны зургадугаар сараас Агаарын бохирдол бууруулах ажлын хэсэг байгуулж, ажиллууллаа. Ажлын хэсэг урин дулаан төдийгүй хүйтний улиралд ч бүх нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр захирамж гаргаж байгаа юм. Захирамжийн талаар маргааш /өнөөдөр/ болох Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд танилцуулна” гэв. Мөн Улаанбаатарт суурьшлын бүс тогтоох буюу улаан шугам татах тухай захирамжийг нийслэлийн Засаг дарга С.Батболд гаргасан байна. Захирамжаар улаан шугам татсан буюу суурьшлын бүсийн тогтоосон хэсгээс гаднах хэсэгт шинээр гэр хороолол төлөвлөж, шинэ суурьшлын бүсийг бий болгохгүй бөгөөд уг газар нь эко газар байхаар тусгажээ. Түүнчлэн “Агаарын чанарын өнөөгийн байдлыг харгалзан нийслэлд агаарын бохирдлын дөрвөн бүсчлэлийг тогтоосон байна. Тодруулбал, нэгдүгээр бүсэд орон сууц, байшин хороолол багтах гэнэ. Уг бүсэд ямар ч тохиолдолд яндангийн утаа гаргах ёсгүй ажээ. Харин 2-4 дүгээр бүсэд тодорхой заагтайгаар аль хэсэгт нь цахилгаан халаагуур, аль хэсэгт нь сайжруулсан түлш хэрэглэх вэ гэдэг асуудлыг захирамжилж өгсөн байна. Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, бүсчлэлээс хамааран төрийн бодлого зохицуулалт, утааг багасгах арга хэмжээ төслүүдийг хэрэгжүүлэх аж. Гурав дахь захирамж нь“Хязгаарлалтын арга хэмжээ авах тухай” юм байна. Энэхүү захирамжаар хот руу ирэх шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахаар болжээ. Тухайлбал, Улаанбаатар хотод зөвхөн зайлшгүй шаардлагаар удаан хугацаанд эмчлүүлэх шаардлагатай хүмүүсийг л шилжиж ирүүлэх гэнэ. Мөн Улаанбаатар хотод зээлд хамрагдан орон сууц худалдаж авсан иргэний шилжилт хөдөлгөөнийг зөвшөөрнө хэмээн захирамжид тусгажээ. Бусад тохиолдолд 2018 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр хүртэл шилжилт хөдөлгөөнийг хориглож байгаа юм байна. Дээрх захирамжийн хяналтад Улаанбаатар хотын мэргэжлийн хяналт, агаарын чанарын байцаагч нар хяналт тавих ажээ.

# УРИЛГА

**БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

**Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага**

-Компани татварын өргүй;
-Санхүүгийн чадамжтай;
-Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

**Санал авах хугацаа**

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

**Хаяг:**
**“Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани**
**Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, UBH центр, 8-р давхар**
**Улаанбаатар 14230**
**Утас: (976) 99140072**
**Факс: (976) 70106644**
**Вебсайт: www.mtz.mn**

NO STRESS

ДУУЛГАХ СОНИН





# “La la Land” “Алтан бөмбөрцөг”-ийг хамлаа

Б.ДАВАА

Кино, телевизийн салбарынхны шилдгүүдийг тодруулах 74 дэх удаагийн “Алтан бөмбөрцөг” наадмын шагнал гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр АНУ-ын Лос Анжелес хотноо зохион байгуулагдлаа. Ёслолын үйл ажиллагааг Жимми Фэллон хөтлөн явуулсан юм. “Алтан бөмбөрцөг” кино, телевизийн салбарын хээнцэр одууд улаан хивснээ алхсанаар эхэлж, ярилцлага өгөх, шилдгүүдийг нэрлэх гэх зарчмаар үргэлжилжээ. Ингээд шилдгүүдийг зарлах мөчид Холливудын алтан үеийнхнийг дүрсэлсэн найруулагч Дэмьен Шазелийн “La la Land” мюзикл кино хамгийн олон номинаци буюу нэр дэвшсэн долоон төрөлдөө шилдгээр шалгарч, энэ удаагийн “Алтан бөмбөрцөг”-ийг хамлаа.

Тус кино “Шилдэг инээдмийн мюзикл кино” төрөлд шалгарснаас гадна гол дүрийн жүжигчид болох Райн Гослинг, Эмма Стөүн нарын жүжигчид шилдэг гол дүрийн эрэгтэй, эмэгтэй номинацид тус тус тэргүүлсэн байна. Түүнчлэн, шилдэг найруулагч, шилдэг зохиол, шилдэг хөгжим, шилдэг киноны дуу гэх зэрэг нийт долоон төрөлд шалгарчээ. Ингэснээр ирэх сард зохион байгуулагдах Оскарт ч тус кино оролцсон номинациуддаа шилдгээр нэрлэгдэх магадлал өндөр болж ирлээ. Харин шилдэг драмын кино төрөлд “Moonlight” кино тэргүүллээ. Улмаар драмын шилдэг гол дүрийн эрэгтэй жүжигчин төрөлд “Manchester by the Sea” кинонд бүтээсэн дүрээрээ жүжигчин Кейси Аффлек, шилдэг гол дүрийн эмэгтэй жүжигчин номинацид “Elle” киногоороо Изабель Юппер нар тус тус нэрлэгджээ. Харин телевизийн салбарт “The Night Manager” цуврал гурван төрөлд ялалт байгуулжээ. Шилдэг эрэгтэй жүжигчний шагнал хүртсэн Райан Гослинг шагналаа гардан авахдаа эхнэр Ева Мендездээ талархал илэрхийлж үг хэлсэн нь олны сэтгэлийг хөдөлгөсөн юм.

Тэрбээр, “Талархал илэрхийлэх олон хүн байгаа ч нэг хүнд тусгайлан баярласнаа илэрхийлмээр байна. Намайг дуулж, бүжиглэж, төгөлдөр хуур тоглож, урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй сайхан бүхнийг мэдэрч байхад миний эхнэр охиноо өсгөн, хоёр дахь охиноо гэдсэндээ тээн, хавдартай тэмцэж байсан ахдаа туслаж байсан юм. Намайг энэ кинонд тоглуулах боломжийг олгохын тулд тэрбээр энэ бүх ачааг үүрээгүй байсан бол одоо энд миний оронд өөр хүн зогсож байх байсан биз. Чамдаа баярлалаа. Амада, Эсмеральда охидуудаа хайртай шүү. Би энэ шагналыг эхнэрийнхээ ах Хуан Карлос Мендезд зориулж байна” хэмээн ярьсан юм. Ингээд шилдгүүдийн жагсаалтыг хүргэе.

**Шилдэг кино /драм/** - “Moonlight”
**Шилдэг кино /инээдмийн, мюзикл/** - La la land
**Шилдэг эрэгтэй туслах дүр**- Аарон Тэйлор-Жонсон, “Nocturnal Animal”
**Шилдэг хөгжим** - “La La Land”
**Шилдэг дуу** - “City of Stars” La La Land
**Шилдэг эмэгтэй туслах дүр** - Виола Дэвис, “Fences”
**Шилдэг эрэгтэй дүр** - Райан Гослинг, “La La Land”
**Шилдэг зохиол** - Дэмьен Шазель, “La La Land”
**Шилдэг хүүхэлдэйн кино** - “Zootopia”
**Шилдэг гадаад хэл дээрх кино** - “Elle”
**Шилдэг найруулагч** - Дэмьен Шазель , “La La Land”
**Шилдэг эмэгтэй дүр** - Эмма Стоун, “La La Land”
**Шилдэг драмын киноны эрэгтэй дүр** - Кейси Аффлек, “Manchester by the Sea”
**Шилдэг драмын киноны эмэгтэй дүр** - Изабель Хаппэрт, “Elle”
**Телевизийн драмын шилдэг эрэгтэй жүжигчин** - Билли Боб Торнтон, “Goliath”
**Телевизийн драмын шилдэг эмэгтэй жүжигчин** - Трэси Эллис Росс, “Black-ish”
**Телевизийн шилдэг инээдмийн эсвэл мюзикл цуврал** - “Atlanta”
**Телевизийн мини-цуврал эсвэл уран сайхны киноны шилдэг эмэгтэй дүр** - Сара Полсон, “The People v. O.J.Simpson: American Crime Story”
**Телевизэд зориулсан богино хэмжээний цуврал эсвэл уран сайхны кино** - “The People v. O.J.Simpson: American Crime Story”
**Телевизэд зориулсан цурал,мини-цуврал эсвэл уран сайхны киноны шилдэг эрэгтэй туслах дүр** - Хью Лори, “The Night Manager”
**Телевизэд зориулсан цуврал, мини-цуврал эсвэл уран сайхны киноны шилдэг эмэгтэй туслах дүр** - Оливия Колман, “The Night Manager”
**Телевизэд зориулсан мини-цуврал эсвэл уран сайхны киноны шилдэг эрэгтэй дүр** - Том Хиддлстон, “The Night Manager”
**Телевизийн драмын киноны шилдэг эмэгтэй дүр** - Клэйр Фой, “The Crown”
**Телевизийн шилдэг драмын кино** - “The Crown”, Netflix
**Телевизийн инээдмийн эсвэл мюзикл цувралын шилдэг эрэгтэй дүр** - Доналд Гловэр, “Atlanta”

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -16
Шөнө -26

Нөгөөдөр
Өдөр -17
Шөнө -28

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН ДУНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 08.40-17.20
**Үс засуулбал:** Жаргал ирнэ



*Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээх, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олдох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

Aanii Bilow



Автобусанд суув. 1000 төгрөгтэй. Тэгээд хариултаа авчих санаатай миний араас автобусанд орж ирсэн нэг нөхрөөс “наашаа өгчих” гэж хэлээд хайрцагт хийх гэж байсан 500 төгрөгийг нь аваад 1000 төгрөгөө өгчихлөө. Тэгсэн мань нөхөр миний 1000 төгрөгийг аваад юу ч болоогүй юм шиг яваад өгөх юм. За яах вэ гэж бодсон ч гэсэн төмс царайлаад гайхаад л үлдлээ. Гэхдээ бодсон чинь дургүй хүрээд байх юм. Нөгөө нөхөр чинь 500 төгрөгөө 1000 болгочихоод додигор амьтан сууж байгаа байх даа. Гоё гарууд байх юм аа.

СОНИРХУУЛАХАД

## М.Энхболдын хүү Ерөнхийлөгч болохоор зүтгэж буй гэнэ

Монголын Үндэсний сагсан бөмбөгийн холбооноос /МҮСБХ/ өчигдөр сэтгүүлчдэд мэдээлэл хийлээ. Монголын сагсан бөмбөгийн холбоо болон МҮСБХ-нд өнгөрсөн онд эвлэлдэн, хамтран ажиллахаар болсон. Тэгвэл сүүлийн үед тус холбоог авах гэсэн оролдлого гарсныг МҮСБХ-оос мэдээлсэн юм. МҮСБХ-ны Ерөнхийлөгч Ц.Цэвэрбал “МҮСБХ нь 2016 оны хоёрдугаар сард Улсын бүртгэлд албан ёсоор бүртгэгдсэн. Сагсан бөмбөгийн хөгжүүлэхийг зорьсон бүх хүн нэгдээд ажиллаж байгаа. Энэ



маань ч тодорхой үр дүнгээ өгөөд байна. Гэтэл сүүлийн үед УИХ-ын дарга М.Энхболдын хүү Э.Анар Улсын бүртгэлийг хүчингүй болгож, өөрөө холбооны ерөнхийлөгч болохоор зүтгэж буйд харамсаж байна. Манай холбоо хамтарч ажиллая гэсэн хүн бүхэнд нээлттэй байгаа. Бид өнгөрсөн онд бүх гишүүдийн хурлаа хийж, Ерөнхийлөгчид өрсөлд гэж санал тавьсан. Гэвч огт хариу өгөөгүй шүү дээ” гэсэн юм. Түүнчлэн энэ үеэр тамирчид МҮСБХ-оос холбооны ажилд саад учруулах асуудлаа зогсоож, хамтран ажиллахыг хүсч байгаагаа энэхүү хэвлэлийн хурлын үеэр хүсч байлаа. Дашрамд дуулгахад, өнгөрсөн онд Монголын сагсчид олон улсын есөн тэмцээнд оролцож, найман медальтай ирсэн байна. Тэр дундаа 3х3 төрлийн сагсан бөмбөгийн оюутны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Монголын баг мөнгөн медальтай ирж, түүхэн амжилтыг үзүүлжээ. 2017 онд сагсан бөмбөгийн ДАШТ-ий урьдчилсан шатны тоглолтууд болох юм. Тиймээс МҮСБХ-ны Ерөнхийлөгч Ц.Цэвэрбал энэхүү урьдчилсан шатанд оролцуулж өгөхийг нийт сагсан бөмбөгчдийнхөө өмнөөс хүсч буйгаа илэрхийлж байлаа.

## А.Баярцэцэг малчин эмэгтэйн дүрд тогложээ



Миссийн тэмцээнд оролцоход заавал хөөрхөн байх албагүй гэдгийг яруу тодоор харуулсан нэгэн бол яах аргагүй “Торго модель” агентлагийн загвар өмсөгч А.Баярцэцэг. Тэрбээр, загвар өмсөхөөс гадна өндөр боловсролтой басхүү чамгүй жүжигчин гэдгээ батлаад амжсан. Тэгвэл загвар өмсөгч А.Баярцэцэг дахин дэлгэцийн уран бүтээлд тоглон, шүтэн бишрэгчиддээ бэлэг барьжээ. Тодруулбал, “Mongolian Social Channel” студийн бүтээл “Явуулын хүн” уран сайхны кинонд Ариунаа гэх хөдөөний эгэл жирийн бүсгүйн дүрд тоглосон байна. Тус кинонд малчин ардын аж байдлыг тусгасан гэнэ. Дашрамд сонирхуулахад, “Явуулын хүн” киноны зураг авалтыг Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт авчээ.

ХӨЛБӨМБӨГ

## Неймар 11 тоглолтод дараалан гоол оруулсангүй



Испанийн Ла лигийн хүрээнд “Барселона” клуб “Вильяррел”-ын эсрэг тулж, 1:1-ээр тэнцсэн билээ. Энэ тоглолтод Месси “Барса”-гийн ганц гоолыг оруулсан. Тэгвэл хамгийн сонирхолтой өдгөө 24 настай Бразилын шигшээн “од” Неймар Каталаны багийн төлөө сүүлийн 11 тоглолтод гоол оруулж чадаагүй байна. Тэрбээр хамгийн сүүлд “Барселона”-гийн төлөө өнгөрсөн оны аравдугаар сарын 19-нд Аваргуудын лигийн хэсгийн шатанд “Манчестер Сити”-г 4:0-ээр хожсон тоглолтод гоол оруулсан юм. Тэгвэл арваннэгдүгээр сард Бразилын шигшээн хамтаар Аргентиныг 3:0-ээр хожиход гоолдсон байна. Неймар одоогоор Ла лигт 14 тоглолтод оролцож, 4 гоол оруулж, 8 оновчтой дамжуулалт өгчихөөд байгаа билээ.